



АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГААНЫ ҮНДСЭН ТАЙЛАН

МОНГОЛ
УЛСЫН
ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

Улаанбаатар хот
2008 он



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРОО

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГААНЫ ҮНДСЭН ТАЙЛАН 2006-2007

**2006 оны 7 сараас 2007 оны 6 сарыг дуусталх
хугацаанд улирлаар явуулсан
Ажиллах Хүчний Судалгааны нэгдсэн тайлан**

Улаанбаатар
2008

Хүснэгт, зургийн жагсаалт
Хавсралт, хүснэгтийн жагсаалт

Бүлэг 1. Удиртгал	5
1.1 Нийтлэг зүйл	5
1.2 Судалгааны зорилго	5
1.3 Судалгааны хугацаа	6
1.4 Тайлангийн агуулга, бүтэц	6
Бүлэг 2. Судалгааны арга зүй, зохион байгуулалт, ойлголт тодорхойлолтууд	8
2.1 Судалгааны хамрах хүрээ	8
2.2 Судалгааны түүвэрлэлт	8
2.3 Судалгааны асуулгын хуудас, ахлагч тоологч нарын сургалт, мэдээлэл цуглуулалт	10
2.4 Мэдээлэл боловсруулалт	12
2.5 Ойлголт тодорхойлолтууд	12
Бүлэг 3. Хүн ам зүйн үзүүлэлтүүд	17
3.1 Нийтлэг зүйл	17
3.2 Хүн ам зүйн үзүүлэлтүүд	17
3.3 Хүн амын тоо, байршил, бүс нутгаар	17
3.4 Хүн амын нас, хүйсийн бүтэц	19
3.5 Хүн ам зүйн ачаалал	20
3.6 Гэрлэлтийн байдал	21
3.7 Өрхийн бүтэц	21
3.8 Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх	22
3.9 Боловсролын түвшин	22
3.10 Сургуульд хамрагдалт	23
3.11 Бичиг үсгийн мэдлэгийн түвшин	24
Бүлэг 4. Ажиллах хүч	26
4.1 Нийтлэг зүйл	26

4.2 Ажиллах хүчний оролцооны түвшин	26
4.3 Насны бүлэг дэх оролцооны түвшин	28
4.4 Эдийн засгийн идэвхгүй хүн ам	30
Бүлэг 5. Ажил эрхлэлт	33
5.1 Тухайн үеийн ажиллагчид	33
5.2 Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ..	34
5.3 Ажиллагчдын тоо, ажил мэргэжлийн ангиллаар	35
5.4 Ажиллагчдын тоо, ажил эрхлэлтийн байдлаар	36
5.5 Ажиллагчдын тоо, байгууллагын хариуцлагын хэлбэрээр	37
5.6 Давхар ажил эрхлэлт	38
Бүлэг 6. Ажилгүйдэл	39
6.1 Нийтлэг зүйл	39
6.2 Ажилгүйчүүдийн тоо	39
6.3 Ажилгүйдлийн түвшин	40
6.4 Ажилгүйчүүдийн боловсролын түвшин	41
Бүлэг 7. Бүрэн бус ажил эрхлэлт	43
7.1 Нийтлэг зүйл	43
7.2 Тухайн үеийн бүрэн бус ажил эрхлэлт	43
7.3 Нэмэгдэл ажил хийх боломжгүй шалтгаан	45
Бүлэг 8. Ажиллах хүчний улирлын хэлбэлзэл	47
8.1 Нийтлэг зүйл	47
8.2 Эдийн засгийн идэвхитэй хүн ам	47
8.3 Ажиллагчдын тоо	49
8.4 Ажил эрхлээгүй хүн ам	51
Бүлэг 9. Ажиллах хүчний 2002/03 ба 2006/07 оны	
судалгаануудын үндсэн үр дүн	53
9.1 Нийтлэг зүйл	53

9.2 Хүн ам зүйн үзүүлэлтүүд	53
9.3 Эдийн засгийн идэвхитэй хүн ам	55
9.4 Ажиллагчдын тоо	56
9.5 Ажил эрхлээгүй хүн ам	58
Бүлэг 10.Түүврийн алдаа	59
10.1 Нийтлэг зүйл	59
10.2 Түүвэрлэлт	59
10.3 Түүврийн алдаа	62

Хүснэгт 1. Ажиллах хүчний түүвэр судалгааны бүлэг тус бүр, сонгогдсон ТАШН, өрхүүдийн тоо	9
Хүснэгт 2. Өрх, хүн амын тоо, хот хөдөө, бүсээр	17
Хүснэгт 3. 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур байгаа гишүүдтэй өрхийн тоо, хот, хөдөө, бүсээр	18
Хүснэгт 4. Өрх, хүн амын тоо, хот, хөдөө, бүсээр	19
Хүснэгт 5. Хүн амын нас, хүйсийн бүтэц, хүйсийн харьцаа	19
Хүснэгт 6. Хүн ам зүйн ачааллын харьцаа, хот, хөдөө, бүсээр	20
Хүснэгт 7. Хүн амын гэрлэлтийн байдал, хот, хөдөө, бүсээр	21
Хүснэгт 8. Өрхийн дүнд эзлэх хувь, ам бүлийн тоо, хот, хөдөө, бүсээр	21
Хүснэгт 9. Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь, ам бүлийн тоогоор	22
Хүснэгт 10. 15, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хот, хөдөө, хүйс, дүнд эзлэх хувиар	23
Хүснэгт 11. 7-19 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин, хот, хөдөө, хүйсээр	23
Хүснэгт 12. Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин, хот, хөдөө, бүсээр	24
Хүснэгт 13. Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин, насны бүлэг, хот, хөдөөгөөр	25
Хүснэгт 14. 15 ба түүнээс дээш насны хүн амын ажил эрхлэлтийн байдал, хот, хөдөө, хүйсээр	26
Хүснэгт 15. 15 ба түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний байдал, судалгааны дүнгээр	27
Хүснэгт 16. 15 ба түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин тухайн насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр	29
Хүснэгт 17. 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн амын дүнд эзлэх хувь, идэвхгүй байгаа шалтгаан, хүйс, байршлаар	31
Хүснэгт 18. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, хүйс, хот, хөдөөгөөр	33
Хүснэгт 19. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, хүйс, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар	34

Хүснэгт 20. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, ажил мэргэжлийн ангиллаар, хувиар	35
Хүснэгт 21. Тухайн үед ажил эрхэлсэн 15, түүнээс дээш насны хүн амын тоо, аж ахуйн нэгж, байгууллагын төрөл, бүс нутгаар	37
Хүснэгт 22. Давхар ажил эрхэлж буй хүн амын тоо, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр	38
Хүснэгт 23. Ажилгүйчүүдийн тоо, ажилгүйдлийн түвшин, хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр	39
Хүснэгт 24. Ажилгүйчүүдийн насны бүтэц, хувиар	40
Хүснэгт 25. Ажилгүйчүүдийн боловсролын түвшин, хүйсээр, дүнд эзлэх хувиар	42
Хүснэгт 26. Нэмэгдэл ажил хийх боломжтой хүмүүс, хүйсээр, хот хөдөөгөөр, бүсээр	43
Хүснэгт 27. Нэмэгдэл ажил хийх боломжтой байсан хугацаа, байршил, бүс нутгаар	45
Хүснэгт 28. Нэмэгдэл ажил хийх боломжгүй байсан шалтгаан, насны бүлэг, байршлаар	46
Хүснэгт 29. 15, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхи, улирлын тооцоогоор	47
Хүснэгт 30. 15, түүнээс дээш насны ажил эрхэлсэн хүн амын тоо, улирлаар	49
Хүснэгт 31. 15, түүнээс дээш насны ажилгүйчүүдийн тоо, улирлаар	52
Хүснэгт 32. Өрх, хүн амын тоо, АХС-ны дүнгээр	54
Хүснэгт 33. 15, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхи, АХС-ны дүнгээр	55
Хүснэгт 34. 15, түүнээс дээш насны ажил эрхэлсэн хүн амын тоо, 2002-2003, 2006-2007 оны АХС-ны дүнгээр	56
Хүснэгт 35. Нийт хүн ам	64
Хүснэгт 36. Ажиллах хүч	65
Хүснэгт 37. Ажиллагчид	66
Хүснэгт 38. Ажилгүйчүүд	67
Хүснэгт 39. Хөдөлмөр эрхэлдэг хүүхэд	68
 Зураг 1. Хүн амын насны бүтэц, 2000 оны ХАОСТ, АХС-ны дүнгүүдээр	 20

Зураг 2. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр, байршлаар	28
Зураг 3. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр	29
Зураг 4. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хот, хөдөөгөөр	30
Зураг 5. 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн амын бүтэц, шалтгаанаар	32
Зураг 6. Тухайн үеийн ажиллагчдын бүтэц, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар	35
Зураг 7. Тухайн үеийн ажиллагчдын ажил эрхлэлтийн байдлын бүтэц, хувиар	37
Зураг 8. Давхар ажил эрхэлсэн хүн амын бүтэц, давхар ажил эрхэлсэн хугацаагаар, хувиар	38
Зураг 9. Ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр	41
Зураг 10. Ажилгүйдлийн түвшин, хүйс, боловсролын түвшнээр, хувиар	42
Зураг 11. Нэмэгдэл ажил хийх боломжтой мөртлөө хийгээгүй шалтгаан, улсын дүнгээр, хувиар	44
Зураг 12. 15 ба түүнээс дээш насны нэмэгдэл ажил хийх боломжгүй байсан хүний тоо, хүйс, байршил, бүс нутгаар	45
Зураг 13. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйс, улирлаар	48
Зураг 14. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, улирлаар	50
Зураг 15. 15, түүнээс дээш насны хүн амын ажил эрхлэлтийн түвшин, хот, хөдөө, улирлаар	51
Зураг 16. Ажилгүйдлийн түвшингийн улирлын тооцоо, хүйсээр, хувиар	51
Зураг 17. Хүн амын насны бүтэц, 1979, 1989, 2000 оны ХАОСТ, 2002-2003, 2006-2007 оны АХС-ны дүнгээр	54
Зураг 18. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр, АХС-ны дүнгээр	55
Зураг 19. Ажиллагчдын эдийн засгийн үйл ажиллагааны салбарын бүтэц, 2002-2003, 2006-2007 оны АХС-ны дүнгээр	57
Зураг 20. Ажиллагчдын ажил эрхлэлтийн байдлын бүтэц, 2002-2003, 2006-2007 оны судалгааны дүнгээр	57
Зураг 21. Ажилгүйдлийн түвшин, хүйсээр, 2002-2003, 2006-2007 оны судалгааны дүнгээр, хувиар	58

Хавсралт хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан хүн амын тоо, насны бүлэг, хүйс, байршлаар

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан хүн амын тоо, бүс, аймаг, нийслэлээр

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан өрхийн тоо, өрхийн тэргүүлэгчийн хүйс, өрхийн ам бүлийн тоо, байршил, бүс, аймаг, нийслэлээр

Хүснэгт 4. 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, идэвхгүй байгаа шалтгаан, хүйс, байршлаар

Хүснэгт 5. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, насны бүлэг, салбараар

Хүснэгт 6. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, байршил, бүс, аймаг, нийслэлээр

Хүснэгт 7. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, насны бүлэг ажил мэргэжлийн ангиллаар

Хүснэгт 8. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, ажил мэргэжлийн ангилал, бүс, байршил, аймаг, нийслэлээр

Хүснэгт 9. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, насны бүлэг ажил эрхлэлтийн байдлаар

Хүснэгт 10. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, ажил эрхлэлтийн байдал, байршил, бүс, аймаг нийслэлээр

Хүснэгт 11. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, насны бүлэг, аж ахуйн нэгж, байгууллагын төрлөөр

Хүснэгт 12. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, байршил, бүс, аймаг нийслэл, аж ахуйн нэгж, байгууллагын төрлөөр

Хүснэгт 13. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, салбар, аж ахуйн нэгж, байгууллагын төрлөөр

Хүснэгт 14. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, салбар, ажил мэргэжлийн ангиллаар

Хүснэгт 15. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, салбар, боловсролын түвшингээр

Хүснэгт 16. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, салбар, ажил эрхлэлтийн байдлаар

Хүснэгт 17. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдлаар

Хүснэгт 18. Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн ба бүртгүүлээгүй ажилгүйчүүдийн тоо, насны бүлэг, хүйсээр

Хүснэгт 19. Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн ба бүртгүүлээгүй ажилгүйчүүдийн тоо, бүс, аймаг, нийслэлээр

Хүснэгт 20. Сүүлийн 30 хоногт ажил хайсан болон хайгаагүй ажилгүйчүүдийн тоо, насны бүлэг, хүйсээр

Хүснэгт 21. Сүүлийн 30 хоногт ажил хайгаагүй ажилгүйчүүдийн тоо, насны бүлэг, хүйс, ажил хайгаагүй гол шалтгаанаар

Хүснэгт 22. Байнгын идэвхтэй хүн амын тоо, насны бүлэг, хүйс, салбараар

Хүснэгт 23. Байнгын идэвхтэй хүн амын тоо, байршил, бүс, аймаг, нийслэл, салбараар

БҮЛЭГ I. УДИРТГАЛ

1.1. Нийтлэг зүйл

Үндэсний статистикийн газарт “Ажиллах хүчний түүвэр судалгаа”-г “Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа” –тай хавсруулан 2002-2003 онд олон улсын жишиг аргачлалын дагуу анх удаа зохион байгуулж, явуулсан билээ. Энэ судалгаа нь олон улсын нийтлэг тодорхойлолт, арга зүйг ашиглан хүн амын эдийн засгийн идэвхийг сүүлийн 7 хоногийн буюу тухайн үеийн, сүүлийн 12 сарын буюу байнгын идэвхийн аргачлалаар тооцох замаар хүн амын ажил эрхлэлтийн байдлыг тодорхойлон, хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлийн холбогдолтой үзүүлэлтүүдийг бүс нутаг, хот, хөдөө, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангилал, ажил эрхлэлтийн байдлаар улирлын нөлөөллийг тусган тооцож гаргаснаараа чухал ач холбогдол бүхий судалгаа болсон.

Ажлын байр, орлогын эх үүсвэрийн хомсдол нь ядуурлын үндсэн шалтгаан болж байгаа өнөө үед хөдөлмөр эрхлэлтийн талаар бодлого, хөтөлбөр боловсруулах, энэ чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээ, төслүүдэд үнэлгээ дүгнэлт өгөх, дүн шинжилгээ хийхэд холбогдох байгууллага, бодлого боловсруулагч нарыг шаардлагатай тоон мэдээллээр тогтмол хангах асуудал зүй ёсоор тавигдаж байна.

АХС-г өмнө нь нэг удаа явуулсан туршлагад үндэслэн ажилгүйдэл, бүрэн бус хөдөлмөр эрхлэлт байсаар байгаа өнөөгийн нөхцөлд хөдөлмөр эрхлэлтийн стратеги, хөтөлбөрийг боловсруулах, үр дүнг дүгнэхэд шаардлагатай хөдөлмөр эрхлэлтийн талаарх статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулах, шалгуур үзүүлэлтүүдийг оновчтой зөв тооцон гаргах, мэдээллийн давтамжийг тогтмолжуулах, хөдөлмөрийн статистикийн системийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэхүү шаардлагын үүднээс АХС-г цаашид явуулах нь зүйтэй гэж үзэн Монгол Улсын “Статистикийн тухай” хуульд 2004 оны 4-р сарын 23-нд нэмэлт өөрчлөлт оруулан, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн ё-д “Хүн амын ажил эрхлэлтийн түүвэр судалгааг улирал тутам явуулж байх”-аар заасан юм.

Нэг талаас дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлэх нөгөө талаас хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаар нарийвчлан тогтмол судлах, ажиллах хүч, ажилгүйдлийн шалгуур үзүүлэлтүүдийг бодитой тооцох зорилгоор 2006 оны 3-р улирлаас 2007 оны 2-р улирлыг дуусталх хугацаанд энэхүү судалгааг явуулсан юм.

ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр(ХХУОУХ)-ийн газраас хүүхдийн хөдөлмөрийн судалгааг өмнөх 2002-2003 оны судалгааны адил Олон улсын хөдөлмөрийн байгууллага(ОУХБ)-аас гаргасан нийтлэг тодорхойлолт, арга зүйн дагуу хавсралт судалгаа болгон явуулах санал тавьж, техник, санхүүгийн туслалцаа үзүүлэн хамтран ажилласан болно.

1.2. Судалгааны зорилго

“Статистикийн тухай” Монгол Улсын хуульд “Хүн амын ажил эрхлэлтийн түүвэр судалгааг улирал тутам явуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлэхийн сацуу хөдөлмөрийн статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулж, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийг бүрэн хамруулсан дүн шинжилгээ хийх, хөдөлмөр

эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн Засгийн газрын бодлого, хөтөлбөр боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, хөдөлмөрийн зах зээлийг зөв төлөвшүүлэн хөгжүүлэхэд нь бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, бизнес эрхлэгчид, шинжлэн судлаачид, төр захиргааны албаны ажилтан хэн бүхэнд гарын авлага, тогтмол мэдээллийн эх сурвалжийг бий болгоход оршино. Үүний тулд ОУХБ-аас гаргасан нийтлэг тодорхойлолт, арга зүйн дагуу хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлийн холбогдолтой үзүүлэлтүүдийг улирлын нөлөөллийг тусган бүс нутаг, байршил, аймаг, нийслэл, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар өргөн хэмжээнд тооцож гаргахад шаардлагатай иж бүрэн тоон мэдээллийг өрхүүдээс цуглуулах зорилт тавьж байгаа юм.

1.3. Судалгааны хугацаа

Судалгааны хамралтын хугацаа нь 4 улирал буюу 2006 оны 7 дугаар сараас 2007 оны 6 дугаар сарыг дуусталх нэг жилийн хугацааг хамарсан. Судалгааны эхний улирлын мэдээллийг 2006 оны 7-9 дүгээр саруудад, хоёрдугаар улирлынхыг 2006 оны 10-12 дугаар саруудад, гуравдугаар улирлынхыг 2007 оны 1-3 дугаар саруудад харин сүүлчийн буюу дөрөвдүгээр улирлын мэдээллийг 2007 оны 4-6 дугаар саруудад цуглуулсан болно. Иймд судалгааны улирлын хугацаа цаг тооллын улирлын хугацаатай таарахгүй байгааг анхаарах хэрэгтэй.

1.4. Тайлангийн агуулга, бүтэц

Энэхүү Ажиллах хүчний судалгааны үр дүнгийн тайлан нь дараах 10 бүлэгтэй. Үүнд:

Бүлэг 1. Удиртгал;

Бүлэг 2. Судалгааны арга зүй, зохион байгуулалт, ойлголт тодорхойлолтууд;

Бүлэг 3. Өрх, хүн амын байдал;

Бүлэг 4. Ажиллах хүч;

Бүлэг 5. Ажил эрхлэлт;

Бүлэг 6. Ажилгүйдэл;

Бүлэг 7. Бүрэн бус ажил эрхлэлт;

Бүлэг 8. Ажиллах хүчний улирлын хэлбэлзэл;

Бүлэг 9. Ажиллах хүчний 2002/03 ба 2006/07 оны судалгаануудын үндсэн үр дүн;

Бүлэг 10. Түүврийн алдаа;

Бүлэг 1-д удиртгал, Бүлэг 2-т судалгаанд хэрэглэсэн арга зүй болон ойлголт тодорхойлолтууд, судалгааны зохион байгуулалтын талаар, Бүлэг 3-т өрх, хүн амын байдлыг байршил, боловсрол, эдийн засгийн байдлаар тодорхойлсон бол Бүлэг 4-т ажиллах хүч, ажиллах хүчний тооцоо, ажиллах хүчний оролцооны түвшин, эдийн засгийн бус үйл ажиллагааны талаар, Бүлэг 5-д тухайн үед болон байнга ажил эрхэлж буй 15 ба түүнээс дээш настай хүн амын талаар, Бүлэг 6-д

ажилгүйдийн түвшин, ажилгүйчүүдийн боловсролын түвшин талаар, Бүлэг 7-д байнгын болон тухайн үед ажил эрхэлж буй 15 ба түүнээс дээш насны хүн амын бүрэн бус ажил эрхлэлтийн байдал, нэмэлт ажил хийх боломжтой хүн амын талаар, Бүлэг 8-д ажиллах хүчний байдлыг улирлаар харьцуулан харуулсан бол Бүлэг 9-д өмнөх 2002-2003 онд явуулсан судалгааны үр дүнг энэ удаагийн судалгааны үр дүнтэй харьцуулалт хийсэн талаар, Бүлэг 10-т судалгааны түүвэрлэлт, түүний алдааны талаар тайлбарласан болно.

БҮЛЭГ II. СУДАЛГАНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТУУД

2.1. Судалгааны хамрах хүрээ

Ажиллах хүчний судалгааг хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодит тоон мэдээллийг улсын хэмжээнд болон бүс нутаг, аймгаар цуглуулан тооцох зорилгоор явагдсан. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд судалгааг байршлын хувьд Монгол Улсыг бүхэлд нь хамруулан өргөн цар хүрээнд явуулахаар төлөвлөж улсын хэмжээнд 4 бүс нутаг (Төв, Баруун, Зүүн, Хангай), Улаанбаатар хотын нийт 12288 өрхийн 5 ба түүнээс дээш насны гишүүдээс асуулга авахад хангалттай гэж үзсэн. Нэг жилийн туршид судалгаанд хамруулахаар төлөвлөсөн нийт 12288 өрхөөс 12286 өрх хамрагдаж, хамралтын хувь 99.9 хувьтай гарлаа.

Тоон мэдээллийг сар бүр цуглуулан улирлаар үр дүнг нэгтгэсэн ба улиралд тутамд нийт түүвэрлэгдсэн өрхийн дөрөвний нэг нь ногдож байв. Энэхүү тайланд нийт 12 сар буюу бүтэн жилээр нэгтгэн гаргасан үзүүлэлтүүдийг тооцохын зэрэгцээ улирлын хэлбэлзэлийг харуулах зорилгоор зарим тоон мэдээллийг улирлаар тооцсон.

Судалгаа нь өрхөд суурилан явагдаж байгаа тул цэргийн хуаран, дотуур байр, засан хүмүүжүүлэх газар, сүм хийд зэрэг нийтийн байруудад түр амьдрагчид, байнгын орон гэргүй хүмүүсийг хамруулаагүй болно. Нийтийн байрууд нь байнгын оршин суух газарт тооцогдохгүйгээс гадна байнгын орон гэргүй хүмүүсийг тодруулан судалгаанд хамруулахад бэрхшээлтэй байдаг зэрэг шалтгаанаар өрхийн судалгаануудад хамруулдаггүй.

2.2. Судалгааны түүвэрлэлт

Судалгааны түүвэрлэлтийн нэгж нь өрх юм. Байнга хамтран амьдарч, нэгтгэн хоол хүнсээ бэлтгэж, нэг тогооноос хоол иддэг нэг буюу хэд хэдэн хүмүүсийг хэлнэ. Эдгээр хүмүүс нь хамаатан садан болон ажил олгогчтойгоо хамтран амьдардаг цусан төрлийн хамааралгүй гэрийн үйлчлэгч, бусад хөлсний ажилчид ч байж болно. Өрхийн ам бүлийн тоонд тухайн өрхөд 6 сараас илүү хугацаагаар эзгүй байгаа (хугацаат цэргийн албан хаагч, оюутан сурагчид, гадаадад ажиллаж амьдарч байгаа болон цагдан хоригдож байгаа) иргэдийг оруулаагүй болно.

Ажиллах хүчний болон Хүүхдийн хөдөлмөрийн 2002-2003 оны судалгааны түүвэрлэлтийн нэгж нь 2000 оны Хүн ам, орон сууцны улсын тооллогын нэгж байсан бол 2006-2007 оны судалгааны нэгжээр Монгол Улсын засаг захиргааны нэгжийг авч, түүвэрлэлтийг 2005 оны өрх, хүн ам, хөдөлмөрийн насны хүн амын тоог үндэслэн өмнө хийсэн судалгааны түүврийн дизайныг сайжруулах замаар хийгдсэн болно. 2000 оны ХАОСТ-оор нийт хүн амын тоо 2373493, өрх 541149 байсан бол 2005 оны жилийн эцсийн байдлаар хүн ам 2562400, өрх 611026 болж өөрчлөгдсөний зэрэгцээ, хүн амын шилжих хөдөлгөөн их байсан нь түүврийн дизайныг дахин сайжруулан(Re design) сүүлчийн оны эцсийн холбогдох тоонд тулгуурлан хийх шаардлага гарсан болно. Нөгөө талаар 2000 оны ХАОСТ-ын нэгжийн нэлээд хэсэг нь байхгүй болсон буюу бүрэн бус болсон тул аймаг, сум,

багийн хүрээгээр судалгааны нэгж гарган түүвэрлэлт хийх шаардлагатай болсон юм. Мөн олон өрх, хүн амтай түүврийн анхан шатны нэгж буюу зарим аймгийн төвийн баг, хотын хэсгүүдийг сегмент болгон хуваах шаардлага түүвэрлэлтийн техникээс шалтгаалан гарч байсан юм. Энэхүү нөхцөл болон түүвэрлэлтийн нэгж, түүвэрлэх өрхийн тооны харьцааны шаардлагын дагуу судалгааны нэгжид оногдох өрхийг 12, нэгжийг 1024 байхаар тогтоосон болно.

Ийнхүү судалгааны түүвэрлэлтийг нарийвчилсан байдлаар хийсэн нь судалгааны үр дүнг аймгаар гаргах боломжтой болсноороо өмнөх судалгаанаас давуу талтай юм.

**Хүснэгт 1: Ажиллах хүчний түүвэр судалгааны бүлэг тус бүр,
сонгогдсон ТАШН, өрхүүдийн тоо**

Бүлгийн дугаар	Бүлгийн нэрс	Нийт өрх	Нийт хүн ам	Түүвэрлэгдэх нэгжийн тоо	Түүвэрлэгдэх өрхийн тоо	Улиралд түүвэрлэгдэх өрхийн тоо	Сард түүвэрлэгдэх өрхийн тоо
1	Архангай	24,276	91,092	32	384	96	32
2	Баян-Өлгий	21,328	95,758	40	480	120	40
3	Баянхонгор	20,935	82,088	32	384	96	32
4	Булган	15,016	56,428	24	288	72	24
5	Говь-Алтай	15,473	63,587	24	288	72	24
6	Дорноговь	13,968	51,582	24	288	72	24
7	Дорнод	18,087	73,981	32	384	96	32
8	Дундговь	12,628	49,934	24	288	72	24
9	Завхан	19,929	78,668	32	384	96	32
10	Өвөрхангай	28,793	108,235	40	480	120	40
11	Өмнөговь	12,798	47,866	24	288	72	24
12	Сүхбаатар	13,339	52,768	24	288	72	24
13	Сэлэнгэ	22,193	90,190	32	384	96	32
14	Төв	23,309	88,491	32	384	96	32
15	Увс	19,800	80,924	32	384	96	32
16	Ховд	19,478	91,687	32	384	96	32
17	Хөвсгөл	29,655	123,416	56	672	168	56
18	Хэнтий	17,941	66,762	24	288	72	24
19	Дархан-Уул	22,238	90,656	40	480	120	40
21	Орхон	20,870	84,297	32	384	96	32
22	Говь-Сүмбэр	3,245	12,625	8	96	24	8
	Аймгийн дүн	395,299	1,581,035	640	7,680	1,920	640
22	Сонгино хайрхан	44,862	204,587	80	960	240	80
23	Баян зүрх	47,459	196,132	80	960	240	80
24	Баянгол	35,294	160,479	64	768	192	64
25	Сүхбаатар	26,097	117,233	48	576	144	48
26	Хан Уул	20,032	87,912	40	480	120	40
27	Чингэлтэй	28,371	130,501	56	672	168	56
28	Налайх	6,521	26,529	8	96	24	8
29	Багануур Багахангай	7,091	29,037	8	96	24	8
	Нийслэлийн дүн	215,727	952,410	384	4,608	1,152	384
	УЛСЫН ДҮН	611,026	2,533,445	1,024	12,288	3,072	1,024

Ажиллах хүчний түүвэр судалгааны бүлэглэлтийг 21 аймаг тус бүрийг нэг бүлэг, Улаанбаатар хотын 9 дүүргийг 8 бүлэгт (хамгийн цөөн өрхтэй 2 дүүргийг нэг бүлэгт хамруулсан) хувааж нийт 29 бүлэглэлт хийсэн. Улаанбаатар хотын дүүргийн хорооны хэсгүүд болон аймгуудын багуудыг түүвэрлэлтийн анхан шатны нэгж (ТАШН) -ээр авч 384 хэсэг, 640 баг нийт 1024 анхан шатны нэгжийг түүвэр судалгаанд хамруулсан.

Ажиллах хүчний түүвэр судалгаанд олон шатат түүврийн арга хэрэглэсэн. Түүвэрлэлтийг хийхдээ таамаглаж байгаа ажилгүйчүүдийн тооны нийт

хүн амд эзлэх хувийн жингээр магадлал хийн тооцсон болно. Нөгөөтэйгүүр түүвэрлэлтийг аймаг, хотын дүүргээр бүлэглэн хуваарилахдаа нийт хүн амд пропорциональ харьцаагаар жигд тархаан тооцсон.

Түүврийн эхний шатанд ТАШН нь хэмжээнд нь пропорциональ магадлалт түүврийн аргаар сонгогдсон (ПМТ), Түүврийн хоёрдугаар шатанд судалгааны нэгж бүрээс 12 өрхийг сонгохдоо ТАШН-ээс энгийн санамсаргүй системчилсэн циклт түүврийн дэд түүвэрлэлтийн техникийг ашигласан болно. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдах өрхийг сонгохдоо 2 шаттай түүвэрлэлтийн (sub-sampling) аргыг хэрэглэсэн.

2.3. Судалгааны асуулгын хуудас, ажлагч тоологч нарын сургалт, мэдээлэл цуглуулалт

Ажиллах хүчний судалгаа болон Хүүхдийн хөдөлмөрийн 2002-2003 онд явуулсан судалгааны асуулга 7 бүлэг бүхий 123 асуулттай байсан бол энэхүү судалгааны асуулга нь 9 бүлэг 159 асуултаас бүрдэж, шинээр 2 бүлэг, 36 асуулт нэмэгдээд байна. Энэ нь өмнөх судалгааны үр дүнг боловсруулах явцад хүн амын ажил эрхлэлт нэн ялангуяа хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг өрхийн нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдтэй уялдуулан судлах, мөн хүн амын ажил эрхлэлттэй салшгүй холбоотой шалтгаануудыг тодруулах зорилгоор хүн амын шилжих хөдөлгөөн, боловсрол, сургалт, албан бус хөдөлмөр эрхлэлттэй холбогдолтой үзүүлэлтүүдийг нэмсэнтэй холбоотой.

Судалгааны зорилго, зорилтууд, хамрах хүрээг харгалзан, тухайн үеийн болон байнгын эдийн засгийн идэвхийн тодорхойлолт, аргачлалыг ашиглан судалгааны асуулгыг дараах мэдээллийг боловсруулан гаргахад чиглүүлж боловсруулсан. Үүнд:

1. Өрхийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд (өрхийн сууцны төрөл, өмчлөл, эзэмшлийн хэлбэр, эрчим хүч, түлш, усан хангамж, хувийн мал, газартай эсэх)
2. Хүн ам зүйн үзүүлэлтүүд (өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох, хүйс, төрсөн он, сар, өдөр, сургуульд суралцсан, суралцаж байгаа эсэх, боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэг, гэрлэлтийн байдал, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан)
3. Сүүлийн 7 хоног буюу тухайн үеийн идэвхи (эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаа, түүнд зарцуулсан цаг, эдийн засгийн идэвхитэй, идэвхигүй байдал, үндсэн болон давхар ажил эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл, ажил эрхлэлтийн байдал, ажил мэргэжлийн ангиллаар, үндсэн ажлынхаа цалин хөлсийг ямар хугацааны давтамжтай авдаг, авч буй цалин, хөлс, орлого)
4. Нэмэгдэл ажил хийх хүсэл, боломж (нэмэгдэл ажил хийх хүсэл, боломжтой эсэх, нэмэгдэл ажил хийх хүсэл боломжгүй байгаа шалтгаан, нэмэгдэл ажил хэрхэн хайсан)
5. Ажилгүйдэл (ажил хийхэд бэлэн байсан эсэх, эдийн засгийн идэвхигүй байсан шалтгаан, ажил хайсан хугацаа, ямар төрлийн/ажил мэргэжлийн ажил хийх хүсэлтэй байгаа, хичнээн төгрөгний цалин хөлс (өдрийн, сарын) авах бодолтой байгаа, хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн)

эсэх, хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн хугацаа, сүүлийн 30 хоногт ажил хайсан эсэх, ажил хайсан хэлбэр, ажил хайгаагүй шалтгаан, ажилгүй байсан хугацаа)

6. Байнгын эдийн засгийн идэвхи (сүүлийн 12 сарын буюу байнгын эдийн засгийн идэвхи, сүүлийн 12 сарын хугацааны үндсэн болон давхар ажил эрхлэлт, ажил эрхлэлтийн байдал, ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрлөөр, ажилгүй байсан хугацаа, ажил хайсан хэлбэр, сүүлийн 12 сард үндсэн болон давхар ажил эрхлэлтээс авсан дундаж цалин хөлс, орлого)
7. Өмнөх үеийн ажил эрхлэлт (өмнөх үеийн ажил эрхлэлт, ажил мэргэжил, ажил эрхлэлтийн байдал, ажиллаж байсан эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл, хамгийн сүүлийн ажлаа хир удаан хийсэн, өмнөх үеийн ажил эрхлэлтийн хамгийн сүүлчийн өдөр, хугацаа, хамгийн сүүлчийн ажлаа хийхээ больсон шалтгаан, ажилгүй байх хугацаандаа ямар орлого, тусламжаар амьдарч байгаа)
8. 5-17 насны хүүхдийн хөдөлмөр эрхлэлт (гэрийнхээ ажилд тусалж байгаа хэлбэрүүд, сургуульд хамрагдалт, сургуульд бүрэн хамрагдаж чадахгүй байгаа шалтгаан, өрхийн аж ахуйн ажилд оролцдог эсэх, анх хэдэн настайгаасаа эхэлж ажил хийсэн, өрхийн аж ахуйд туслах, ажиллах болсон шалтгаан, өрхөөс гадуур ямар нэг ажил хийх болсон шалтгаан, хүүхдүүд ажлын байрныхаа нөхцөлд сэтгэл ханамжтай байдаг эсэх, хийж буй ажил нь хүүхдэд бие болон сэтгэлийн дарамт учруулдаг эсэх, шөнө, оройн цагаар ажилладаг эсэх, хэр олон удаа ажилладаг, хүүхэд ажлаасаа болж өвдөж гэмтсэн эсэх, ямар өвчин гэмтэл авсан, олсон орлогоо юунд зарцуулдаг, өдөрт өөрт нь чөлөөт цаг гардаг эсэх)

ОУХБ-ын ХХУОУХ-ийн газрын захиалгын дагуу хүүхдийн хөдөлмөрийн хавсарга судалгаа явуулж байгаа тул олон улсын стандартын дагуу АХС-ны асуулга авах өрхийн гишүүдийн насны доод хязгаарыг 5 насаар тогтоосон болно.

Энэ судалгааг зохион байгуулан явуулах ажлын хэсэг нь асуулгын хуудас, зааврыг боловсруулахдаа НХХЯ, БСШУЯ, АОЭХ, МҮЭХ, ОУХБ болон ТББ, ОУБ-уудтай зөвшилцөх, саналыг нь авах, турших замаар асуулгыг хэд хэдэн удаа шинэчлэн боловсронгуй болгож эцэслэн, ҮСГ-ын даргын 2006 оны 6-р сарын 28-ны өдрийн 01/69 тоот тушаалаар батлуулсан.

Улсын хэмжээнд энэхүү судалгааг чанартай явуулах зорилгоор 2006 оны 6 дугаар сарын 28-наас 30-ны өдрүүдэд судалгааны ахлагч, тоологч нарт зориулсан нийт 60 хүн оролцсон сургалтыг ажлын хэсэг төвлөрсөн хэлбэрээр зохион байгуулсан. Энэхүү сургалтын үеэр аймаг, нийслэлийн ажиллах хүчний судалгааны ахлагч нарыг судалгааны бөглөгдсөн асуулгыг кодлох, компьютерт шивэх дадлага хийлгэж, үр дүнг хэлэлцүүлэн тодруулга, тайлбар хийсэн. Түүнчлэн ахлагч, тоологч нарыг сургалтын үеэр болон судалгааны мэдээлэл цуглуулах ажилд шаардагдах гарын авлагаар хангасан.

Судалгааны тоологч, ахлагч нар сонгогдсон өрхүүдэд очиж 5 ба түүнээс дээш насны гишүүн бүртэй нэг бүрчлэн уулзаж ярилцлага хийх замаар мэдээллээ цуглуулсан. Судалгааны нэгдүгээр улирлын мэдээллийг цуглуулах ажил 2006 оны 7-9 сард, хоёрдугаар улирлынх 2006 оны 10-12 сард, гуравдугаар улирлынх 2007 оны 1-3 сард, дөрөвдүгээр улирлынх 2007 оны 4-6 сард хийгдэж дууссан. Монгол Улсад хүн амын шилжих хөдөлгөөн их байгааг харгалзан судалгаа авах үеэр өрх эзгүй байх тохиолдолд судалгаанд сонгогдсон өрхөө бүрэн хамруулахын тулд тухайн өрхөд 2-3 удаа дахин очиж, судалгаанд хамруулах ажилд хяналт тавьж

ажиллав. Үүний дүнд нийт 4 улирлын хэмжээнд 12288 өрхөөс асуулга бүрэн авч чадав. Судалгааны ажлын хэсгийн гишүүд, байгууллагын удирдлагуудаас бүрдсэн хяналтын баг АХС-ны ажлын явцыг нийт 11 аймаг болон Улаанбаатар хотод хянаж шалган, гарсан ололт, дутагдлыг тухай бүр нь танилцуулж, шаардлагатай арга хэмжээ авч ажилласан.

2.4. Мэдээлэл боловсруулалт

АХС-ны мэдээлэл боловсруулах ажлыг 2 үе шаттайгаар явуулсан. Судалгааны асуулгын загвар болон мэдээллийг компьютерт бэлтгэн оруулах, бүрдэлтийг шалган хүлээн авах, хянах, засварлах, боловсруулах, нэгдсэн үр дүнг гарган авах ажлуудыг ҮСГ-т, харин өрхөөс ярилцлага авч, цуглуулсан мэдээллийг зааврын дагуу шалгаж, кодлон компьютерт шивж оруулах, шалгах, засварлан төвд дамжуулах ажлыг аймаг, нийслэлийн статистикийн ажиллах хүчний судалгааны баг хийж гүйцэтгэсэн.

Тооллого, судалгааны мэдээлэл боловсруулдаг CSPro3.1 багц программаар АХС-ны мэдээллийг компьютерт шивж оруулах, шалгах, засварлах програмыг хийж, бэлэн болсон мэдээллийн үр дүнг боловсруулж хүснэгт гаргахдаа SPSS13.0 програмыг ашигласан. Судалгааны мэдээллийг боловсруулж дууссаны дараа ажлын хэсэг ОУ-ын зөвлөхийн хамт тодорхой үзүүлэлтүүд дээр статистикийн дүн шинжилгээ хийж, судалгааны боловсруулалтын үр дүнг хянах, илэрсэн алдааг засварласны үндсэн дээр судалгааны үр дүнгийн хүснэгтүүдийг бэлтгэн гаргаж тайлан бичихэд хэрэглэв.

2.5. Ойлголт тодорхойлолтууд

Энэ хэсэгт “Ажиллах хүчний судалгаа”-ны асуулгын хуудсанд орсон зарим ойлголт, тодорхойлолтыг багтаасан болно. Эдгээр нь ҮСХ-оос явуулсан болон явуулж байгаа бусад судалгааны ойлголттой зэрэгцүүлэх боломжтой байлгахын үүднээс томъёологдсон бөгөөд НҮБ болон ОУХБ-аас санал болгосон олон улсын нийтлэг стандарт бүхий тодорхойлолтыг үндэслэн Монгол Улсын онцлогийг тусгасан боловсруулсан болно.

Өрх

Өрх гэдэг нь байнга хамтран амьдарч, орлогоо нэгтгэн хоол хүнсээ бэлтгэж, нэг тогооноос хоол иддэг нэг буюу хэд хэдэн хүмүүсийг хэлнэ. Эдгээр хүмүүс нь хамаатан садан болон ажил олгогчтойгоо хамтран амьдардаг, цусан төрлийн хамааралгүй, гэрийн үйлчлэгч, бусад хөлсний ажилчид ч байж болно.

Хүцжэд

1989 онд тунхагласан НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенц, 1999 онд баталсан ОУХБ-ын Хүүхдийн Хөдөлмөрийн Тэвчишгүй Хөдөлмөрийн Конвенцэд (182) тодорхойлсноор 18-аас доош насны хүн амыг хүүхэд гэж үзнэ. 5 хүртэлх насны хүүхэд ажил хөдөлмөр эрхлэх, сурах насанд хүрээгүй, балчир гэж нийтээр хүлээн зөвшөөрсний дагуу МХХС-нд 5-17 насны хүүхдийг хамруулсан.

Өрхийн тэргүүлэгч

Өрхийн тэргүүлэгч гэдэг нь бусад гишүүд нь өрхийн тэргүүн хэмээн хүлээн зөвшөөрсөн, насанд хүрсэн, өрхийн гишүүн юм. Хэрвээ тухайн сууцанд нэгээс олон өрх амьдран сууж байвал төдий тооны өрхийн тэргүүн байна.

Эдийн засгийн үйл ажиллагаа / ажил /

НҮБ-ын 1993 оны ҮТС-ийн хүрээнд эдийн засгийн үйл ажиллагааг тодорхойлсоны дагуу цалин хөлс, ашиг орлого олох зорилгоор болон өөрсдийн хэрэглээндээ зориулан эрхэлж буй өрхийн аж ахуйн үйл ажиллагааг ажил гэж хэлнэ. Ажил нь цалин хөлстэй болон цалин хөлсгүй, албан болон албан бус хэлбэртэй байж болно. Жишээлбэл, өөрийн өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцож буй хүнийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байна гэж үзнэ.

Эдийн засгийн бус үйл ажиллагаа

Өөрийн өрхийн гэрийн ажилд оролцож буй хүүхэд нь эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн буюу эдийн засгийн идэвхигүйд тооцогдоно. Үүнд:

- Гэр орон цэвэрлэх, хувцас бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлах;
- Хувцас угаах, индүүдэх, гэр байшин, эд хогшил сэргээн засах;
- Хоол унд хийх, аяга таваг угаах;
- Хүүхэд асрах;
- Өвчтэй хүн, өндөр настангуудыг асрах
- Гэрийнхээ хэрэгцээт зүйлийг худалдаж авах, дэлгүүр явах.

Ажиллагч

Ажиллагч гэдэг нь ажиллах хүчинд хамаарагдах тухайн хугацаанд ажил, хөдөлмөр эрхэлж байгаа болон тухайн долоо хоногт ажил эрхлээгүй ч ажилтай байсан хүнийг хэлнэ. Тухайн хугацаанд (сүүлийн долоо хоногт) ямар нэг байдлаар ажил хөдөлмөр эрхэлсэн (нэг цагаас дээш хугацаагаар) хүнийг ажилтай гэнэ. Өвчлөл, гэмтэл, амралт, чөлөө, цаг агаарын таагүй байдал, ажил хаялт болон бусад шалтгаанаар түр хугацаагаар ажил эрхлэхгүй байгаа ч ажилтай, бизнес эрхэлдэг бол тухайн хүнийг ажиллагч гэж үзнэ.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч

Бусад ажиллагчдын оролцоогүйгээр аж ахуйн нэгж, байгууллага, хамтарсан үйлдвэрийг удирдаж байгаа хүнийг хувиараа хөдөлмөр эрхлэгч гэнэ. Харин өрхийн гишүүд цалин хөлсгүйгээр энд ажиллаж болно.

Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч

Өрхийн аж ахуйн нэгжид цалин хөлсгүйгээр нэг цагаас доошгүй ажилласан хүн. Ялангуяа хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын салбарт өрхийн аж ахуй зонхилж байдаг тул цалин хөлсгүй оролцогч их байдаг. Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон хүүхдүүдийг хөдөлмөр эрхэлсэн гэж үздэг.

Ажилгүйчүүд

Ажилгүйчүүд гэдэг нь ажиллах хүчинд хамаарагдах тухайн хугацаанд ажил, хөдөлмөр эрхлээгүй байгаа болон тухайн долоо хоногт ажил эрхлээгүй боловч ажил эрхлэхэд бэлэн байсан, ажил хөдөлмөр идэвхитэй хайсан хүнийг хэлнэ. Ажил хөдөлмөр эрхлэдэггүй ч ажил эрхлэх боломжтой байгаа, ажилд орох өргөдлөө өгсөн болон ярилцлаганд орохоор хүлээж байгаа хүнийг мөн ажилгүйчүүд гэж тодорхойлно.

Байнгын болон тухайн үе

Энэхүү судалгаанд “тухайн үеийн” болон “байнгын” гэсэн хугацааг хэрэглэсэн. Тухайн үе гэдэгт судалгаа явагдаж байгаа үеийн өмнөх долоо хоног, өөрөөр хэлбэл сүүлийн долоо хоног, байнгын гэдэгт судалгаа явагдаж байгаа үеийн өмнөх 12 сар, өөрөөр хэлбэл сүүлийн 12 сар гэсэн хугацааг авсан болно.

Эдийн засгийн идэвхитэй хүн ам

НҮБ-ын үндэсний тооцооны системийн хүрээнд, тодорхой цаг хугацаанд тодорхойлогдсон бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагчид, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүйчүүдийг эдийн засгийн идэвхитэй хүн амд тооцдог. Эдийн засгийн идэвхитэй хүн амыг урт хугацаагаар хэмжигдэх байнгын идэвхитэй хүн ам, нэг долоо хоног буюу нэг өдрийн хугацаагаар хэмжигдэх тухайн үеийн идэвхитэй хүн ам буюу “Ажиллах хүч” гэсэн хоёр аргаар тодорхойлно.

Байнгын идэвхитэй хүн ам

Заагдсан хязгаараас дээш настай (АХС-гаар 15 ба түүнээс дээш насыг авсан) ажилтай болон ажилгүй байсан нь урт хугацаагаар буюу хуанлийн жилийн (сүүлийн 12 сарын) туршид эрхэлсэн үндсэн үйл ажиллагааныхаа байдлаар тодорхойлогддог хүн амыг хэлнэ.

Тухайн үеийн идэвхитэй хүн ам

Ажиллах хүч буюу тухайн үеийн идэвхитэй хүн амд ажилтай болон ажилгүй байсан нь судалгааны өмнөх сүүлийн 7 хоногт эрхэлсэн үндсэн үйл ажиллагааных нь байдлаар тодорхойлогдож байгаа ажиллагчид болон ажилгүйчүүдийн доторхи тодорхой шаардлагыг хангах бүхий л хүмүүсийг хамруулна.

Эдийн засгийн идэвхигүй хүн ам

Тогтоосон насны хязгаараас дээш насны байнгын болон тухайн үеийн эдийн засгийн идэвхитэй хүн амд хамаарагдахгүй хүн ам болон тогтоосон насны хязгаараас доош насны хүнийг эдийн засгийн идэвхигүй хүн ам гэнэ. Эдийн засгийн идэвхигүй хүн амыг урт хугацаагаар хэмжигдэх байнгын идэвхигүй хүн ам, нэг долоо хоног буюу нэг өдрийн хугацаагаар хэмжигдэх тухайн үеийн идэвхигүй хүн ам гэсэн хоёр аргаар тодорхойлно.

Байнгын идэвхигүй хүн ам

Урт хугацаанд буюу сүүлийн 12 сарын туршид эрхэлсэн үндсэн үйл ажиллагаагаараа эдийн засгийн идэвхитэй хүн амд тооцогдохгүй (ажиллагчид болон ажилгүйчүүдийн алинд ч хамаарахгүй) хүмүүсийг эдийн засгийн байнгын идэвхигүй хүн ам гэнэ. Үүнд: оюутан сурагч, гэрийн ажилчид, тэтгэврийн орлого авдаг хүмүүсийг хамруулна.

Тухайн үеийн идэвхигүй хүн ам

Сүүлийн 7 хоногт сургуульд суралцаж байгаа, гэрийн ажлаа хийж байгаа, тэтгэвэрт гарсан болон өндөр настай, тахир дутуу зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллагчид болон ажилгүйчүүдийн алинд ч хамаарахгүй хүмүүсийг тухайн үеийн эдийн засгийн идэвхигүй хүн ам буюу ажиллах хүчинд хамаарагдахгүй хүн ам гэнэ.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар

Тухайн хүний ажиллаж байгаа ажлын байр, үйлдвэрийн газар, байгууллагын үйлдвэрлэдэг үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр тодорхойлогдоно. Олон Улсын Стандарт Ангилал 3-т нийцүүлэн боловсруулсан “Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ыг ашигласан.

Ажил мэргэжил

Цалин, хөлс, орлого олох зорилгоор тухайн хүний хийж гүйцэтгэж буй эдийн засгийн үйл ажиллагааны ажил, мэргэжлийн төрлийг ажил, мэргэжил гэнэ. Хэрвээ тухайн хүн ажилгүй байгаа бол эрхлэхэд бэлэн байгаа ажил, мэргэжлийн төрлийг тухайн хүний ажил, мэргэжил гэж үзнэ.

Үндсэн ажил

Тухайн хугацаанд (сүүлийн долоо хоног, сүүлийн 12 сард) нэгээс олон ажил цалинтай болон хувиараа эрхэлж байгаа бол нийгмийн болон хууль зүйн тал, цалин хөлсний хэмжээ, ажиллаж байгаа цагаас нь хамааруулан үндсэн ажлыг тодорхойлно. Хэрвээ тухайн хүн зөвхөн нэг л ажил эрхэлдэг бол түүнийг үндсэн ажилд тооцно.

Давхар ажил

Тухайн хугацаанд (сүүлийн долоо хоног, сүүлийн 12 сард) нэгээс олон ажил цалинтай болон хувиараа эрхэлж байгаа бол нийгмийн болон хууль зүйн тал, цалин хөлсний хэмжээ, ажиллаж байгаа цагаас нь хамааруулан үндсэн ажлаас бусад ажлыг давхар ажил гэж тодорхойлно.

Бүрэн бус ажил эрхлэлт

Тухайн хүний ажлын туршлага, мэргэжлийн чадварт дүйцэхүйц бус ажил хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд бүрэн бус ажил эрхлэлт байдаг. Бүрэн бус ажил эрхэлж байгаа хүн нь цалин, хөлстэй болон хувиараа эрхэлж байгаа тухайн үйл ажиллагаанд тогтоогдсон цагаас бага цагаар өөрийн хүслээр бус ажиллаж байгаа тухайн хугацаанд нэмэлт ажил хайж байгаа болон нэмэлт ажил эрхлэхэд бэлэн байгаа хүн юм.

Ажил олгогч

Өөрийн ажил мэргэжлээс үл хамааран нэг болон түүнээс дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, хамтарсан үйлдвэрийг удирдаж байгаа хүнийг ажил олгогч гэнэ.

Цалин хөлс

Мөнгөн болон биет хэлбэрээр авч байгаа хөлс, урамшуулал, гарын мөнгө, ашиг орлогын хувь, илүү цаг ажилласны мөнгө, ажил олгогчоос хангаж байгаа хоол хүнс, байрыг цалин хөлсөд хамааруулна.

Бичиг үсгийн мэдлэг

Тухайн хүн энгийн өгүүлбэрийг уншиж мөн бичиж чаддаг бол бичиг үсэг мэддэг гэнэ. Харин зөвхөн өөрсдийнхөө нэр юмуу тоог уншиж, бичиж чаддаг эсвэл уншиж чаддаг мөртлөө бичиж чаддаггүй бол бичиг үсэг мэддэг гэж үзэхгүй.

Оюутан

Тухайн хүний үндсэн үйл ажиллагаа нь их, дээд сургууль, коллежид суралцаж байгаа болон хичээлийг нь бие даан суралцагчдыг оюутан гэж үзнэ.

БҮЛЭГ III. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

3.1. Нийтлэг зүйл

Энэ бүлэгт АХС-ны дөрвөн улирлын турш хийсэн (2006 оны 7 дугаар сараас 2007 оны 6 дугаар сарыг дуусталх) тооллогын нийт 1024 нэгжийн 12,288 өрхөөс цуглуулсан мэдээлэл, түүн дээр үндэслэн тооцсон судалгааны үр дүнг танилцуулж байна. Түүвэрлэлтийн загварын дагуу тооллогын нэгж бүрээс 12 өрх, нийт 12288 өрх сонгогдож хамрагдах ёстойгоос нийт 12,288 өрх хамрагдаж, хамралтын түвшин 100.0 хувьтай байна.

АХС нь ОУХБ-аас гаргасан нийтлэг ойлголт, тодорхойлолт, арга зүйн дагуу хийгдэж байгаа ажиллах хүчний 2 дахь түүвэр судалгаа юм. ҮСХ-оос энэхүү судалгааны тоо мэдээ, үр дүнг улирал тус бүрээр болон бүтэн жилээр нэгтгэн боловсруулсан. Өөрөөр хэлбэл энэ тайлан нь улирал бүрээр болон дөрвөн улирлаар нэгтгэн боловсруулсан тоо мэдээ, үр дүнд үндэслэсэн бөгөөд тайланд зөвхөн үндсэн үр дүнг харуулсан хүснэгтүүдийг оруулсан болно.

3.2. Хүн ам зүйн үзүүлэлтүүд

“Ажиллах хүчний судалгаа”-гаар хүн амын тоо, насны бүлэг, хүйс, боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, бичиг үсгийн мэдлэг, өрхийн ам бүлийн тоо, гэрлэлтийн байдал гэх мэт хүн ам зүйн холбогдолтой үндсэн мэдээлэл гарч байна. Судалгаанд 2 шатат түүврийн аргыг ашиглан бүлэглэлт хийсэн тул хүн ам зүйн үзүүлэлтүүдийг дөрвөн бүс нутаг, хот, хөдөө гэсэн ангиллаар гаргав. Хүн ам зүйн үзүүлэлтүүдийг эдгээр ангиллаар тооцон гаргахад түүврийн нийт хэмжээ хангалттай гэж үзэж, дөрвөн улирлын нэгдсэн тоонд үндэслэн дэлгэрэнгүй хүснэгтүүдийг байршил болон бүсээр боловсруулан гаргав.

3.3. Хүн амын тоо, байршил, бүс нутгаар

Судалгааны үр дүнг тархаасан тооцоогоор манай орны 597218 өрхөд нийт 2.415 мянган хүн ам байгаагийн дотор 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа хүний тоо 178.0 мянга байна. Өрхийн ам бүлийн дундаж тоо 4.0 байна.

Хүснэгт 2. Өрх, хүн амын тоо, хот хөдөө, бүсээр

Байршил/ Бүс	Өрх		Хүн ам Тоо	Өрхөөс гадуур байгаа Тоо	Нийт хүн амын тоо		Өрхийн ам бүлийн дундаж тоо
	Тоо	%			Тоо	%	
Хот	345528	57.9	1310504	78174	1388678	57.5	4.0
Хөдөө	251690	42.1	926828	99830	1026658	42.5	4.1
Төв	104707	17.5	378675	29504	408179	16.9	3.9
Зүүн	49420	8.3	183505	4078	187583	7.8	3.8
Баруун	96261	16.1	384301	45315	429616	17.8	4.5
Хангай	140989	23.6	522079	53518	575597	23.8	4.1
Улаанбаатар	205842	34.5	768771	45589	814360	33.7	4.0
Дүн	597218	100.0	2237332	178004	2415335	100.0	4.0

Судалгаанд хамрагдсан өрхийн хүн амыг тооцохдоо сургуулийн хүүхдийн дотуур байр, цэргийн хуаран, засан хүмүүжүүлэх газар, эмнэлэг зэрэг нийтийн байранд амьдрагчдыг хамруулаагүй болно. Өрхийн хүн амын тоог байршил, бүсээр Хүснэгт 1-д харуулав. Нийт хүн амын 57.5 хувь буюу 1,388 мянган хүн хотод амьдарч байна. Хөдөөгийн өрхийн ам бүлийн дундаж тоо хотынхоос өндөр буюу 4.1 байна. Нийт өрхийн 35 орчим хувь нь Улаанбаатар хотод байгаа бөгөөд нийслэлийн өрхийн ам бүлийн дундаж тоо улсын дундажтай тэнцүү буюу нэг өрхөд 4.0 хүн ногдож байна. Хүн амын суурьшлыг бүс нутгаар авч үзэхэд харилцан адилгүй байгаа бөгөөд зүүн бүсэд хамгийн бага, тухайлбал нийт хүн амын 8.3 хувь нь амьдарч байна.

Засаг захиргааны нэгжээс гаргуулан авдаг хүн амын ажил эрхлэлтийн 2007 оны жилийн эцсийн тайлангийн дүнгээр суурин хүн амын тоо 2,602 мянга байна.

АХС-нд нийтийн байранд амьдрагчид болон 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа өрхийн гишүүдийг хамруулаагүй болно.

6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур байгаа гишүүдийн тоог хот, хөдөө, бүсээр нь гаргаж Хүснэгт 3-д үзүүлэв.

Хүснэгт 3. 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур байгаа гишүүдтэй өрхийн тоо, хот, хөдөө, бүсээр

Хот, хөдөө/ Бүс	Өрхийн тоо	Өрхийн гишүүдийн тоо	Өрхөөс гадуур амьдарч байгаа хүний тоо	Үүнээс:		
				Суралцаж байгаа	Ажиллаж байгаа	Бусад
Хот	38042	99518	78174	38228	26219	13727
Хөдөө	55701	136786	99830	78176	14775	6818
Төв	18122	45279	29504	20542	5633	3328
Зүүн	2436	6675	4078	1908	1567	603
Баруун	25663	65686	45315	35980	7410	1924
Хангай	30299	76007	53518	41688	7811	4019
Улаанбаатар	17223	42657	45589	16286	18573	10731
Дүн	93744	236304	178004	116404	40995	20606

Тухайн өрхийн гишүүн боловч 6 сараас дээш хугацаагаар эзгүй байсан өрхийн гишүүд нийт хүн амын 7.4 хувийг эзэлж байгаа бөгөөд эдгээр хүмүүсийг судалгаанд хамруулах эсэхээс хамаарч нийт хүн амын тоо болон өрхийн ам бүлийн дундаж тоог газар зүйн байршлаар тооцож гаргасан нь үр дүнд нөлөөлж байна. Ямар нэг сургууль, курст суралцан өрхөөс гадуур амьдарч байгаа хүн 116404 байхад ажил эрхлэн өрхөөс гадуур амьдарч байгаа хүн 40995 байна. Судалгаагаар 6 сараас дээш хугацаагаар эзгүй байсан өрхийн гишүүдийн талаарх мэдээллийг цуглуулаагүй болно.

Иймээс судалгааны тайланд орсон хүснэгтүүд нь өрхөөс гадуур амьдарч байгаа цэрэг, хоригдол, дотуур байранд амьдарч байгаа хүмүүс, 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа өрхийн гишүүдийг оруулахгүйгээр тооцсон хүн амын тоонд үндэслэн хийгдсэн болно. Үүнийг судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийхдээ анхаарах шаардлагатай. Хүснэгт 4-т судалгаанд хамрагдсан хүн амын тоог бүс нутаг, хот, хөдөөгөөр харуулав.

Хүснэгт 4. Өрх, хүн амын тоо, хот, хөдөө, бүсээр

Байршил/ Бүс	Өрх		Өрхийн ам бүлийн дундаж тоо	Бүгд		Эрэгтэй %	Эмэгтэй %
	Тоо	%		Тоо	%		
Хот	345528	57.9	4.0	1310504	100.0	47.8	52.2
Хөдөө	251690	42.1	4.1	926828	100.0	50.6	49.4
Төв	104707	17.5	3.9	378675	100.0	49.5	50.5
Зүүн	49420	8.3	3.8	183505	100.0	49.9	50.1
Баруун	96261	16.1	4.5	384301	100.0	49.6	50.4
Хангай	140989	23.6	4.1	522079	100.0	49.9	50.1
Улаанбаатар	205842	34.5	4.0	768771	100.0	47.6	52.4
Улсын дүн	597218	100.0	4.0	2237332	100.0	49.0	51.0

3.4. Хүн амын нас, хүйсийн бүтэц

Хүн амын нас, хүйсийн бүтцийг Хүснэгт 5-д харуулав. Нийт хүн амын дотор 0-14 насны хүүхэд 27.8 хувийг эзэлж байгаа бөгөөд хүйсээр нь авч үзэхэд эрэгтэйчүүдийн 29.4 хувь, эмэгтэйчүүдийн 26.3 хувь нь энэ насны бүлэгт хамрагдаж байна.


Хүснэгт 5. Хүн амын нас, хүйсийн бүтэц, хүйсийн харьцаа

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Хүйсийн харьцаа ¹
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	
00 – 04	175571	7.8	87499	8.0	88073	7.7	99.3
05 – 09	209127	9.3	108089	9.9	101039	8.9	107.0
10 – 14	237149	10.6	126485	11.5	110664	9.7	114.3
15 – 19	278816	12.5	141483	12.9	137333	12.0	103.0
20 – 24	210246	9.4	100171	9.1	110075	9.6	91.0
25 – 29	187117	8.4	86935	7.9	100182	8.8	86.8
30 – 34	184566	8.2	90342	8.2	94223	8.3	95.9
35 – 39	168625	7.5	80063	7.3	88563	7.8	90.4
40 – 44	159786	7.2	75113	6.9	84673	7.4	88.7
45 – 49	131207	5.9	61940	5.7	69267	6.1	89.4
50 – 54	95932	4.3	44563	4.1	51368	4.5	86.8
55 – 59	61521	2.7	28623	2.6	32898	2.9	87.0
60- 64	52279	2.3	25560	2.3	26720	2.3	95.7
65-69	33393	1.5	16284	1.5	17109	1.5	95.2
70+	51997	2.4	22604	2.1	29393	2.5	76.9
Дүн	2237332	100	1095754	100.0	1141578	100.0	96.0

¹ 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо

Зураг 1-д Хүн амын насны бүтцийг хүн ам, орон сууцны 2000 оны тооллого болон АХС-ны дүнгүүдээр харуулав. Судалгаагаар нийт хүн амын 68.4 хувийг 15-64 насны хүн ам, 3.8 хувийг 65 ба түүнээс дээш насны хүн ам тус тус эзэлж байна. Нийт хүн амын 0-14 насны хүүхдийн дүнд эзлэх хувь буурсаар байгаа нь зургаас харагдаж байна.

Зураг 1. Хүн амын насны бүтэц, 2000 оны ХАОСТ, АХС-ны дүнгүүдээр



3.5. Хүн ам зүйн ачаалал

Хүн ам зүйн ачааллыг тооцохдоо 15 хүртэлх насны хүүхэд болон 65 ба түүнээс дээш насны хүн амын тооны нийлбэрийг 15-64 насны хүн амын тоонд харьцуулж гаргах бөгөөд судалгаагаар энэ үзүүлэлт манай улсын хувьд 46.2 хувь гарлаа. Хүснэгт 6-д Хүн ам зүйн ачааллыг хот, хөдөө, бүсээр харуулснаас үзэхэд Улаанбаатар хотод хамгийн бага 38.4 хувь, баруун бүсэд хамгийн өндөр 57.4 хувь гарав. Өөрөөр хэлбэл баруун бүсийн хөдөлмөрийн насны 100 хүн тутамд ажил хийхэд нас нь бага, эсвэл нас нь өндөр 57 хүн ногдож байна гэсэн үг юм. Өмнө дурьдсанчлан сургууль, курст суралцах зорилгоор 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа 116404 залуучуудыг хамруулаагүйгээс энэ харьцаа доогуур гарсан.

Хүснэгт 6. Хүн ам зүйн ачааллын харьцаа, хот, хөдөө, бүсээр

Хүн ам зүйн ачаалал	Бүгд	Хот	Хөдөө	Төв	Зүүн	Баруун	Хангай	УБ
	%	%	%	%	%	%	%	%
Залуу насны (0-14)	40.6	35.8	48.0	48.0	41.6	52.1	44.2	32.5
Ахимаг насны (65+)	5.6	5.6	5.6	5.6	6.7	5.3	5.0	5.9
Улсын дундаж	46.2	41.4	53.6	53.6	48.3	57.4	49.2	38.4

3.6. Гэрлэлтийн байдал

Судалгаагаар 15, түүнээс дээш насны бүх хүмүүсийн гэрлэлтийн байдлыг гэрлэсэн, огт гэрлээгүй, хамт амьдардаг, тусгаарласан, салсан, бэлбэсэн гэсэн 6 бүлэгт хувааж авч үзсэн. Монгол Улсын 15, түүнээс дээш насны нийт хүн амын 53.3 хувь нь гэрлэсэн, 34.9 хувь нь огт гэрлээгүй, 7.1 хувь нь бэлбэсэн байна.

Гэрлэлтийн мэдээллийн үнэн зөвийг гэрлэсэн эрэгтэйчүүдийн тоо, гэрлэсэн эмэгтэйчүүдийн тоотой ойролцоо тэнцүү байдлаар үнэлдэг. Ингэж шалгаж үзэхэд гэр бүл болсон эрэгтэй, эмэгтэйчүүдийн тоо хот, хөдөөд адил гарч байгаа нь судалгааны энэ асуултад өгсөн хариулт үнэн бодитой болохыг харуулж байна.

Хүснэгт 7. Хүн амын гэрлэлтийн байдал, хот, хөдөө, бүсээр

Гэрлэлтийн байдал	Бүгд			Хот		Хөдөө	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
	%	%	%	%	%	%	%
Огт гэрлээгүй	34.9	37.9	32.1	39.1	34.4	36.1	28.3
Гэрлэсэн	53.3	55.1	51.7	52.9	47.4	58.1	58.7
Хамт амьдардаг	1.5	1.5	1.5	2.1	1.9	0.7	0.8
Тусгаарласан	1.0	0.6	1.4	0.8	1.9	0.3	0.5
Салсан	2.2	1.3	3.1	1.5	3.9	1.0	1.7
Бэлбэсэн	7.1	3.6	10.2	3.6	10.5	3.8	10.0
Дүн, %	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0
15, түүнээс дээш насны хүн амын тоо	1615485	773682	841803	454392	524039	319290	317764
Гэрлэсэн хүний тоо	861185	426106	435080	240484	248523	185622	186557

3.7. Өрхийн бүтэц

Хүснэгт 8-д нийт өрхийн тоог ам бүлийн тоо, хот, хөдөө, бүс нутгаар харууллаа. Судалгаагаар гарсан өрхийн ам бүлийн тоо нь түр эзгүй байсан өрхийн гишүүдийг оруулаагүйгээс шалтгаалан доогуур гарсан байна. Нийт өрхийн 7.6 хувь нь ганц бие өрх байна. Харин 7 ба түүнээс дээш ам бүлтэй өрх улсын дүнгээр 5.0 хувьтай байна. Баруун бүсэд ийм өрхийн эзлэх хувь хамгийн өндөр буюу 7.6 хувь байгаа бөгөөд энэ бүсэд өрхийн ам бүлийн дундаж тоо 4.0 байна. Өрхөөс түр эзгүй байгаа гишүүдийг оруулж тооцсоноор өрхийн ам бүлийн дундаж тоо Улаанбаатар хотод 4.0 байхад баруун бүсэд 4.5 (Хүснэгт 4-г үзнэ үү) байна.

Хүснэгт 8. Өрхийн дүнд эзлэх хувь, ам бүлийн тоо, хот, хөдөө, бүсээр

Өрхийн ам бүлийн тоо	Улсын дүн	Хот	Хөдөө	Төв	Зүүн	Баруун	Хангай	УБ
	%	%	%	%	%	%	%	%
1	7.6	6.6	9.0	9.1	8.7	5.6	8.2	7.1
2-3	37.0	37.1	36.7	37.2	35.2	33.7	37.7	38.2
4-6	50.4	51.0	49.6	49.9	51.8	53.1	49.3	49.8
7+	5.0	5.3	4.6	3.8	4.3	7.6	4.8	4.8
Дүн, %	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	597218	345528	251690	114700	48500	97900	138900	168800
Түр эзгүй байгаа хүнийг оруулаагүй өрхийн ам бүлийн дундаж тоо	3.7	3.8	3.7	3.6	3.7	4.0	3.7	3.7

3.8. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх

Судалгааны үр дүнгээр нийт өрхийн 20.5 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байгаа бөгөөд энэ харьцаа хөдөөд буурч 14.5 хувь болж байна. Хүснэгт 9-д эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийг ам бүлийн тоо болон хот, хөдөөгөөр харууллаа.

Хүснэгт 9. Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь, ам бүлийн тоогоор

Өрхийн ам бүлийн тоо	Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх		
	Бүгд	Хот	Хөдөө
	%	%	%
1	47.2	54.2	40.2
2-3	27.5	33.7	19.0
4-6	12.3	15.7	7.4
7+	11.3	15.4	4.9
Улсын дундаж , %	20.5	24.9	14.5

Ер нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүд гол төлөв цөөхөн ам бүлтэй байна. Өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь багасч байна. Тухайлбал ганц бие өрхийн 47.2 хувийг эмэгтэй тэргүүлэгчтэй өрх эзэлж байхад, 2-3 ам бүлтэй өрхийн 27.5 хувь, 4-6 ам бүлтэй өрхийн 12.3 хувь, 7-оос дээш ам бүлтэй өрхийн 11.3 хувийг эмэгтэй тэргүүлэгчтэй өрх эзэлж байна.

3.9. Боловсролын түвшин

Судалгаагаар хүн амын эзэмшсэн боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, бичиг үсгийн мэдлэгийн талаархи мэдээллийг цуглуулсан. 15 ба түүнээс дээш насны хүмүүсийн эзэмшсэн боловсролын түвшинг хүснэгт 9-д харуулав. Хүснэгтээс харахад хот, хөдөөгийн алинд ч эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эзэмшсэн боловсролын түвшин бараг ойролцоо, гэхдээ эмэгтэйчүүдийнх эрэгтэйчүүдийнхээс арай дээгүүр байна. Хүснэгт 10-т эрэгтэйчүүдийн 4.0 хувь, эмэгтэйчүүдийн 3,9 хувь нь сургуульд огт сурч байгаагүй, эрэгтэйчүүдийн 14.1 хувь, эмэгтэйчүүдийн 13.1 хувь нь бага боловсролтой байна. Хөдөөд энэ харьцаа нилээд өндөр буюу 7.4 хувь нь огт сурч байгаагүй, 21-24 хувь нь бага боловсрол эзэмшсэн байна. Хотын хүн амын бараг 14.0 хувь нь бакалаврын болон магистрийн цол эзэмшсэн байхад энэ нь хөдөөд 4.0 хүрэхгүй хувьтай байна. Хүн амын боловсролын түвшинг хот, хөдөөгөөр харьцуулж үзэхэд хөдөөд доогуур гарч байна.

Хүснэгт 10. 15, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хот, хөдөө, хүйс, дүнд эзлэх хувиар

Боловсролын түвшин	Бүгд			Хот			Хөдөө	
	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %	Эрэгтэй %	Эмэгтэй %	Эрэгтэй %	Эмэгтэй %	
Боловсролгүй	3.9	4.0	3.9	1.6	1.7	7.5	7.4	
Бага	13.6	14.1	13.1	7.2	7.9	24.0	21.6	
Бүрэн бус дунд	26.2	28.7	23.8	22.1	18.4	38.0	32.9	
Бүрэн дунд	29.6	28.8	30.3	36.3	35.1	18.2	22.4	
Мэргэжлийн анхан шатны	5.9	6.4	5.4	7.2	6.0	5.2	4.4	
Тусгай мэргэжлийн/ бүрэн бус дээд	10.6	8.9	12.2	12.1	15.3	4.3	7.1	
Дээд	10.2	9.1	11.3	13.5	15.7	2.8	4.1	
Дүн, %	100	100	100	100	100	100	100	
15, түүнээс дээш насны хүн амын тоо	1615485	773681	841804	454392	524040	319289	317765	

3.10. Сургуульд хамрагдалт

Судалгааны үр дүнгээр 7-19 насны хүн амын 85.2 хувь нь, үүнээс эрэгтэйчүүдийн 83.4 хувь, эмэгтэйчүүдийн 87.2 хувь нь сургуульд суралцаж байна. Сургуулийн насанд хүрсэн хүүхдүүд сургуульд оройтож орж байгаа нь сургуульд хамрагдалтын түвшинг бууруулахад нөлөөлж байгааг Хүснэгт 11-аас үзэж болно. Хот, хөдөөгийн алинд ч охидын сургуульд хамрагдалтын хувь хөвгүүдийнхээс дээгүүр байгаа сонирхолтой дүр зураг харагдаж байна. Хөдөөд анх сургуульд орохоос эхлэн сургууль төгсөх хүртэлх бүх шатанд охидын сургуульд хамрагдалтын түвшин хөвгүүдийнхээс өндөр байна. Ялангуяа хөдөөгийн өсвөр насны охидын сургуульд хамрагдалтын түвшин мөн насны хөвгүүдийнхээс дээгүүр байгаа нь бусад хөгжиж буй орнуудаас нэлээд ялгаатай байна. Хөдөөд мал аж ахуйд туслах зорилгоор хөвгүүд сургууль завсардаж, мөн боловсрол эзэмшсэн залуучууд ажил олоход хэцүү болж байгаа зэрэг нь сургуульд хамрагдалтын түвшинд нөлөөлж байгаа юм.

Хүснэгт 11. 7-19 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин, хот, хөдөө, хүйсээр

Бүтэн нас	Одоогоор сургуульд сурч байгаа								
	Улсын дүн			Хот			Хөдөө		
	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %
7	78.3	77.1	79.5	85.0	86.9	83.3	71.0	68.0	74.8
8	95.3	94.1	96.6	96.3	94.8	97.7	94.2	93.6	95.1
9	96.1	95.2	97.1	97.6	97.3	97.9	94.4	92.6	96.2
10	97.5	97.9	97.1	98.4	98.3	98.5	96.5	97.4	95.7

Хүснэгт 11-ийн цргэлжлэл

Бүтэн нас	Одоогоор сургуульд сурч байгаа								
	Улсын дүн			Хот			Хөдөө		
	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %
11	96.0	95.8	96.2	96.8	95.7	98.1	95.0	95.8	94.2
12	94.2	91.4	97.2	95.1	92.4	98.1	93.1	90.1	96.1
13	95.3	94.4	96.4	97.9	98.2	97.7	91.9	89.7	94.8
14	93.7	92.5	95.0	97.2	96.6	97.8	88.2	86.5	90.4
15	89.7	87.5	91.8	94.6	93.3	96.0	81.5	78.4	84.8
16	86.7	83.4	90.4	94.4	94.0	94.7	73.9	67.2	82.2
17	79.7	74.6	85.6	89.3	85.4	93.6	64.6	59.2	71.7
18	62.2	58.8	65.5	73.5	71.9	75.1	41.2	35.8	46.9
19	49.1	43.6	54.0	62.9	60.3	65.0	26.3	18.9	33.8
07-19 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын хувь	85.2	83.4	87.2	90.1	89.4	90.9	78.3	75.4	81.6
Сургуульд хамрагдсан хүүхдийн тоо	547010	278260	268751	337591	170626	166964	209420	107633	101787
Нийт хүн ам	641964	333638	308326	374538	190943	183595	267426	142695	124731

3.11. Бичиг үсгийн мэдлэгийн түвшин

Судалгаагаар бичиг үсэг мэддэг эсэхийг тодорхойлохын тулд энгийн захиа уншиж бичиж чадах уу гэж асуусан. Энгийн бичиг захиаг уншиж, бичиж чадаж байвал бичиг үсэгт тайлагдсанд тооцсон. Харин зөвхөн өөрийнхөө нэрийг унших эсвэл тоо уншиж чаддаг боловч бичиж чаддаггүй бол тэр хүнийг бичиг үсэгт тайлагдсанд тооцоогүй. Насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдалтын хувийг тодорхойлохдоо 15, түүнээс дээш насны нийт хүн амын дотор энгийн бичиг захиа уншиж, бичиж чаддаг хүний эзлэх хувиар тооцлоо. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшин 97.8 хувь гарсан бол энэ удаагийн судалгаагаар эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин ойролцоо 98.6 хувьтай байна.

Хүснэгт 12-д хөдөөд бичиг үсгийн мэдлэгийн түвшин 97,5 хувь байхад хотод үүнээс 2.5 пунктээр дээгүүр байгааг харуулж байна.

Хүснэгт 12. Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин, хот, хөдөө, бүсээр

Хот, хөдөө/бүс	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
	%	%	%
Хот	99.4	98.7	98.3
Хөдөө	97.5	97.7	97.4
Төв	98.9	98.8	98.9
Зүүн	96.7	96.9	96.5
Баруун	97.8	97.8	97.7
Хангай	98.3	98.5	98.2
Улаанбаатар	99.6	99.6	99.5
Улсын дүн	98.6	98.7	98.6

Дараах хүснэгтээс харахад 64 хүртэлх насны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин 98-аас дээш хувьтай байна.

**Хүснэгт 13. Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин,
насны бүлэг, хот, хөдөөгөөр**

Насны бүлэг	Улсын дүн			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
15 – 24	98.4	98.0	98.8	99.3	99.1	99.6	97.0	96.4	97.5
25 – 34	99.0	98.8	99.2	99.7	99.6	99.6	98.2	97.9	98.6
35 – 44	98.9	99.0	98.8	99.5	99.5	99.4	98.1	98.3	97.8
45 – 54	99.0	99.1	99.0	99.5	99.5	99.5	98.4	98.6	98.1
55 – 64	99.0	99.6	98.4	99.7	99.9	99.5	97.7	99.1	96.3
65+	95.7	98.7	93.2	97.4	99.7	95.5	93.1	97.2	89.4
Дүн	98.6	98.7	98.6	99.4	99.4	99.3	97.5	97.7	97.4

БҮЛЭГ IV. АЖИЛЛАХ ХҮЧ

4.1 Нийтлэг зүйл

НҮБ-ын Үндэсний Тооцооны системд тодорхойлсны дагуу тодорхой цаг хугацаанд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд ажиллах хүчээ оруулж буй нийт хүмүүсийг эдийн засгийн идэвхтэй хүн ам гэж үздэг. НҮБ-ын Үндэсний Тооцооны системийн тодорхойлолтоор үйлдвэрлэл, үйлчилгээ гэдэг нь борлуулах, бараа солилцох болон өөрийн хэрэгцээнд зориулан бараа бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, үйлчилгээ эрхлэхийг хэлдэг.

Тухайн үеийн эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүчийг сүүлийн 7 хоногт ажил эрхэлж байсан болон ажил эрхлээгүй боловч ажил эрхлэхэд бэлэн байсан ажил хөдөлмөр идэвхтэй хайсан, ажилгүй байсан хүмүүс бүрдүүлдэг. Сургуульд суралцаж байгаа, гэрийн ажил хийж байгаа, тэтгэвэрт гарсан болон өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллагчид болон ажилгүйчүүдийн алинд ч хамаарахгүй хүмүүсийг эдийн засгийн идэвхгүй буюу ажиллах хүчинд хамаарагдахгүй хүн ам гэж үздэг.

Хэдийгээр Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжоор хөдөлмөр эрхлэх насыг 16-59 нас гэж заасан боловч танилцуулж буй ажиллах хүчний судалгаанд хүн амын эдийн засгийн идэвхийг 15 ба түүнээс дээш насаар тооцсон нь олон улсын аргачлалд ойртуулах, бусад улс орныхтой харьцуулах боломжийг бүрдүүлж өгч байгаа юм.

4.2 Ажиллах хүчний оролцооны түвшин

Судалгааны дүнг тархаасан тооцоогоор 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо 1615,485 байгаагаас 47.9 хувь нь буюу 773,682 нь эрэгтэй, 52.1 хувь буюу 841,803 нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 14. 15 ба түүнээс дээш насны хүн амын ажил эрхлэлтийн байдал, хот, хөдөө, хүйсээр

Байршил/ Тухайн үеийн байдал	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Улсын хэмжээнд						
Тухайн үеийн идэвхитэй хүн ам	1,013,465	62.7	522,471	67.5	490,994	58.3
Ажиллагчид	898,932	55.6	463,780	59.9	435,152	51.7
Ажилгүйчүүд	114,533	7.1	58,691	7.6	55,842	6.6
Тухайн үеийн идэвхигүй хүн ам	602,020	37.3	251,211	32.5	350,809	41.7
15, түүнээс дээш насны хүн ам	1,615,485	100.0	773,682	100.0	841,803	100.0
Хот						
Тухайн үеийн идэвхитэй хүн ам	529,195	54.1	268,534	59.1	260,661	49.7
Ажиллагчид	442,498	45.2	224,544	49.4	217,954	41.6
Ажилгүйчүүд	86,697	8.9	43,990	9.7	42,707	8.1
Тухайн үеийн идэвхигүй хүн ам	449,237	45.9	185,858	40.9	263,379	50.3
15, түүнээс дээш насны хүн ам	978,432	100.0	454,392	100.0	524,040	100.0
Хөдөө						
Тухайн үеийн идэвхитэй хүн ам	484,270	76.0	253,937	79.5	230,333	72.5
Ажиллагчид	456,434	71.6	239,236	74.9	217,198	68.4
Ажилгүйчүүд	27,836	4.4	14,701	4.6	13,135	4.1
Тухайн үеийн идэвхигүй хүн ам	152,783	24.0	65,353	20.5	87,430	27.5
15, түүнээс дээш насны хүн ам	637,053	100.0	319,290	100.0	317,763	100.0

Хүснэгт 14-ийн цргэлжлэл

Байршил/ Тухайн үеийн байдал	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Улсын хэмжээнд						
АХОТ*		62.7		67.5		58.3
Ажил эрхлэлтийн түвшин		88.7		88.8		88.6
Ажилгүйдлийн түвшин		11.3		11.2		11.4
Хот						
АХОТ		54.1		59.1		49.7
Ажил эрхлэлтийн түвшин		83.6		83.6		83.6
Ажилгүйдлийн түвшин		16.4		16.4		16.4
Хөдөө						
АХОТ		76.0		79.5		72.5
Ажил эрхлэлтийн түвшин		94.3		94.2		94.3
Ажилгүйдлийн түвшин		5.7		5.8		5.7

* АХОТ = Ажиллах хүчний оролцооны түвшин

15, түүнээс дээш насны нийт хүн амын 62.7 хувь буюу 1013,465 нь тухайн үеийн эдийн засгийн идэвхтэй хүн ам (ЭЗИХА) байна. Ажиллах хүч буюу ЭЗИХА-ыг сүүлийн 7 хоногт ажил эрхэлж байгаа болон ажил эрхлээгүй боловч ажил эрхлэхэд бэлэн байсан, ажил хөдөлмөр идэвхтэй хайсан ажилгүй хүмүүс бүрдүүлдэг. Эдийн засгийн идэвхтэй хүн амын 898,932 нь ажиллагчид, 114,533 нь ажилгүйчүүд байна. Нийт эдийн засгийн идэвхтэй хүн амын 52.2 хувь буюу 529,195 нь хот, суурин газарт, 47.8 хувь буюу 484,270 нь хөдөө орон нутагт амьдарч байна.

2006-2007 оны АХС+ХХС-ны нэгдсэн үр дүн буюу хүн амын ажиллах хүчний эдийн засгийн идэвхийн байдлын үндсэн үзүүлэлтүүдийг 2002-2003 оны АХС+ХХС болон засаг захиргааны бүртгэлд үндэслэн гаргадаг Хүн амын ажил эрхлэлтийн 2007 оны жилийн тайлангийн дүнтэй харьцуулан Хүснэгт 15-д үзүүлж байна.

Хүснэгт 15. 15 ба түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний байдал, судалгааны дүнгээр

Эдийн засгийн идэвхийн байдал	2002-2003 ажиллах хүчний судалгаа	2006-2007 оны ажиллах хүчний судалгаа	2007 оны ажил эрхлэлтийн жилийн тайлан*
А/ Хүн амын тоо, мян.хүн			
15, түүнээс дээш насны хүн ам	1,539.2	1,615.4	1,642.2
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	1,004.8	1,013.4	1,054.0
Ажиллагчид	862.5	898.9	1024.1
Ажилгүйчүүд	142.3	114.5	29.9
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	534.4	602.0	588.2
Б/ Түвшин, хувиар			
Ажиллах хүчний оролцоо	65.3	62.7	64.2
Ажил эрхлэлт	85.8	88.7	97.2
Ажилгүйдэл	14.2	11.3	2.8

* 2007 оны АЭТ-д хөдөлмөрийн насны доод хязгаарыг 16 насаар авсан. АЭТ нь засаг захиргааны мэдээлэлд үндэслэдэг бөгөөд ажилгүйчүүдийн тоо нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо болно.

ҮСХ-оос засаг захиргааны бүртгэлд үндэслэн жил бүр гаргадаг хүн амын ажил эрхлэлтийн 2007 оны жилийн тайлангаар ажиллах хүчний нийт тоо 1054,000

байгаагийн 1024,100 нь ажиллагчид, 29,900 нь аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүд байна.


2002-2003 оны АХС+ХХС-ны нэгдсэн үр дүн 2006-2007 оны нэгдсэн үр дүнтэй ойролцоо гарч байгаа нь ОУХБ-аас гаргасан нийтлэг тодорхойлолт, арга зүйгээр хийгдсэнтэй холбоотой юм.

Иймд тодорхойлолт, аргачлалын зөрүүгээс гадна дээр дурьдсан шалтгаанаар энэ удаагийн судалгааны дүнг бусад тооллого, судалгаа, мэдээ тайлангийн дүнтэй шууд харьцуулах боломжгүй байгаа юм.

Ажиллах хүчний оролцооны түвшин /АХОТ/-г хөдөлмөрийн насны нийт хүн амд эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувиар тодорхойлдог.

2006-2007 оны ажиллах хүчний судалгаагаар АХОТ нь улсын хэмжээнд 62.7 хувь гарсан бол 2002-2003 оны АХС+ХХС-ны жилийн дүнгээр 65.3 хувь, харин 2007 оны ажил эрхлэлтийн жилийн тайлангаар 64.2 хувьтай байна. Судалгаагаар АХОТ хот, суурин газарт 54.1 хувь, хөдөөд үүнээс харьцангуй өндөр 76.0 хувьтай байгаа нь хот, суурин газарт сургуульд хамрагдалтын түвшин хөдөө орон нутгийнхнаас өндөр байгаатай холбоотой юм. Иймээс хотод АХОТ хөдөөгийнхөөс 21.9 пунктээр доогуур буюу эрэгтэйчүүдийнх 54.1 хувь, эмэгтэйчүүдийнх 59.1 хувь байна. Дараах Зураг 2-т АХОТ-г нийт дүнгээр, хүйсээр болон байршлаар харууллаа.

Зураг 2



4.3 Насны бүлэг дэх оролцооны түвшин

Ажиллах хүчний оролцооны түвшин хоорондоо ямар ялгаатай байгааг харуулах зорилгоор насны бүлэг дэх оролцооны түвшинг 5 насны бүлгээр тооцож гаргадаг. Үүний дагуу 5 ба түүнээс дээш насны хүмүүсийг 5 насны бүлэгт хуваан ажиллах хүчний оролцооны түвшинг нийт дүнгээр болон хүйсээр задаргаа хийн тооцов. Хүснэгт 16-д 15, түүнээс дээш насны хүн амын АХОТ-г нийт дүнгээр үзүүлэв. Ажиллах хүчний оролцооны түвшин 15-19 насанд 24.1 хувьтай байснаа даруй өсч, 25-29 насанд 80.1 хувь хүрч байна. 25-44 насанд энэ түвшин 80.1-86.4 хувьтай, харин түүнээс дээшхи насанд буурч эхэлж байна. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин ерөнхийдөө өндөр байгаа нь улсын хэмжээний ажиллах хүчний оролцооны түвшинд нөлөөлсөн. Бүх насны бүлэгт эрэгтэйчүүдийн


ажиллах хүчний оролцооны түвшин эмэгтэйчүүдийнхээс өндөр байгаа бөгөөд хөдөө орон нутагт эрэгтэй, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин хот, суурин газрынхаас өндөр гарч байна.

Хүснэгт 16. 15 ба түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин тухайн насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр

Насны бүлэг	Улсын хэмжээнд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
15-19	24.1	27.6	20.4	11.2	12.3	10.0	45.7	51.4	39.3
20-24	58.7	64.3	53.6	45.3	50.2	41.2	79.8	84.4	75.1
25-29	80.1	86.8	74.3	73.1	82.0	65.8	89.6	93.0	86.5
30-34	84.6	89.5	80.0	79.5	86.5	73.5	91.5	93.0	89.8
35-39	86.1	90.8	81.8	82.7	87.8	78.4	91.2	94.8	87.5
40-44	86.4	87.6	85.4	84.6	86.9	82.6	89.2	88.6	89.7
45-49	82.8	85.4	80.4	79.7	82.9	76.8	87.7	89.3	86.3
50-54	67.5	76.8	59.4	59.3	69.9	50.8	79.6	86.1	73.3
55-59	52.1	69.5	37.0	39.5	59.1	23.4	73.2	85.8	61.2
60-64	28.3	35.6	21.4	16.2	24.1	9.1	51.7	56.0	47.2
64-69	20.9	24.6	17.3	9.3	15.9	2.9	40.8	40.2	41.3
70 +	12.3	17.7	8.0	3.5	6.3	1.6	24.8	31.9	18.5
Улсын дундаж	62.7	67.5	58.3	54.1	59.1	49.7	76.0	79.5	72.5

Хөдөөгийн эрэгтэйчүүдийн АХОТ 25-54 насны хоорондох бүлэгт 86.1-94.8 хувь, харин 40-44 насанд эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин хот, хөдөө аль алинд нь хамгийн өндөр байгаа нь сонирхол татаж байна. Энэ нь эмэгтэйчүүд залуу насандаа сурч боловсрох, гэрийн ажил хийх, хүүхэд төрүүлж байдагтай холбоотой байж болох юм (Зураг 3, 4-ыг үзнэ үү).


Зураг 3. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр



Зураг 3-д насны бүлэг дэх АХОТ-г харуулав. Энэ зургаас харахад 25-49 насанд ажиллах хүчний оролцооны түвшин эрэгтэй, эмэгтэй хүмүүст адилхан өндөр гарч, 90.0 хувьд хүрсэн байна. Эдгээр насны бүлэгт эмэгтэйчүүдийн оролцооны түвшин ерөнхийдөө өндөр, эрэгтэйчүүдийнхтэй харьцуулбал бага зэрэг доогуур байна. Харин 40-44 насанд АХОТ эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн хувьд нилээд ойролцоо гарчээ.

Хөдөөгийн эрэгтэй, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин өндөр байгаа нь улсын хэмжээний АХОТ-нд нөлөөлж байна. Хөдөө орон нутагт энэ түвшин өндөр байгаа тул тухайн үед эдийн засгийн идэвхгүй хүн ам нь хот, суурингийн идэвхгүй хүн амаас доогуур, түүний тэн хагаст ч хүрэхгүй байгаатай холбоотой.

Зураг 4. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хот, хөдөөгөөр



Хөдөө орон нутагт АХОТ хотынхоос өндөр байгаа нь ерхийн аж ахуйд суурилсан нүүдлийн мал аж ахуйн онцлог, мөн сургууль боловсролын үйлчилгээний хүртээмж харьцангуй бага байдагтай холбоотой байж болох юм.

4.4 Эдийн засгийн идэвхгүй хүн ам

Сүүлийн 7 хоногт ажил хийгээгүй, ажил хайгаагүй, харин гэрийн ажилтай, өндөр насны тэтгэвэрт, сургуульд суралцдаг болон бусад шалтгааны улмаас идэвхгүй байсан нийт хүн амыг тухайн үеийн эдийн засгийн идэвхгүй хүн ам буюу ажиллах хүчнээс гадуурх хүн амд оруулдаг. Иймд сүүлийн 7 хоногт наад зах нь 1 цаг ажил хийгээгүй /эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй/, ажлын байргүй, ажил хийхэд бэлэн бус байсан хүмүүсийг тухайн үеийн эдийн засгийн идэвхгүй хүн амд тооцов.

Судалгаагаар 15 ба түүнээс дээш насны нийт 1,615,485 хүний 37.3 хувь буюу 602,020 нь эдийн засгийн идэвхгүй бүлэглэлд багтаж байгаагийн 251,211 нь эрэгтэйчүүд, 350,809 нь эмэгтэйчүүд байна.

Эдийн засгийн идэвхгүй хүн амын 74.6 хувь буюу 449,237 нь хот, суурин газарт, 25.4 хувь буюу 152,783 нь хөдөө орон нутагт байна. Хөдөө орон нутаг ажиллах хүчний оролцооны түвшин өндөр байгаа нь тухайн үеийн эдийн засгийн идэвхгүй хүн амын тоог бууруулахад нөлөөлжээ. Тухайн үеийн эдийн засгийн идэвхгүй байдлыг гэрийн ажилтай, сургуульд суралцдаг, өндөр насны тэтгэвэр,

хөгжлийн бэрхшээлтэй, ажил хийхийг хүсээгүй, хүүхэд асардаг, өвчтэй байсан, хөдөлмөрийн насанд хүрээгүй, бусад гэсэн шалтгаанаар ангилан харуулав.

Эдийн засгийн идэвхгүй хүн амын 227,500 нь суралцаж байгаа, 145,100 нь өндөр настан, тэтгэврийнхэн, 84,600 нь гэрийн ажилтай, 31,800 нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, 38,000 нь хүүхэд асарч байгаа, 15,800 нь өвчтэй, 9,500 нь ажил хийхэд бэлэн бус, 11,100 нь хөдөлмөрийн нас хүрээгүй 15 настай, 38,600 нь дээрхээс бусад шалтгаантай хүмүүс байна.

Хүснэгт 17. 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн амын дүнд эзлэх хувь, идэвхгүй байгаа шалтгаан, хүйс, байршлаар


Шалтгаан	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэрийн ажил	14.1	12.2	15.4	12.8	10.7	14.3	17.8	16.4	18.9
Суралцдаг	37.8	42.7	34.3	39.9	45.8	35.7	31.6	33.7	30.0
Тэтгэвэр, өндөр настан	24.1	21.2	26.2	23.9	21.0	25.9	24.7	21.8	26.9
Хөгжлийн бэрхшээлтэй	5.3	6.6	4.3	4.6	5.8	3.8	7.2	8.9	6.0
Ажил хийхэд бэлэн бус	1.6	2.4	1.0	1.6	2.5	1.0	1.4	2.1	0.9
Хүүхэд асарсан	6.3	0.6	10.4	6.9	0.7	11.3	4.5	0.4	7.5
Өвчтэй байсан	2.6	3.1	2.3	2.7	3.0	2.6	2.3	3.7	1.3
Хөдөлмөрийн нас хүрээгүй	1.8	2.4	1.4	1.8	2.2	1.5	2.0	3.0	1.2
Өвчтөн, өндөр настан асарсан	0.9	0.7	1.1	0.8	0.8	0.8	1.2	0.4	1.9
Бусад	5.5	8.0	3.7	4.9	7.5	3.1	7.1	9.5	5.3
Дүн (%)	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
(Тоо)	602,000	251,200	350,800	449,200	185,800	263,400	152,800	65,400	87,400

Нийт эрэгтэйчүүдийн 42.7 хувь, эмэгтэйчүүдийн 34.3 хувь нь сургуульд суралцаж байгаа гэж хариулсан нь эдийн засгийн идэвхгүй байгаагийн үндсэн шалтгаан болж байна. Эрэгтэйчүүдийн 21.2 хувь, эмэгтэйчүүдийн 26.2 хувь өндөр настай буюу тэтгэвэрт гарсан, 12.2 болон 15.4 хувь нь гэрийн ажилтай тул эдийн засгийн идэвхгүй байна.

Хүн амын эдийн засгийн идэвхгүй байдлын үндсэн шалтгаан нь хот, суурин газарт болон хөдөө орон нутагт адилхан сурч боловсрох явдал /хотод 39.9 хувь, хөдөөд 31.6 хувь/ болон өндөр насны тэтгэвэрт байгаа нь харагдаж байна. Хот, суурин газрын эдийн засгийн идэвхгүй хоёр эрэгтэй хүний нэг /45.8 хувь/ нь суралцаж буй тул ажил хийдэггүй, хийх боломжгүй гэж хариулжээ. Хүснэгт 17-оос үзэхэд хөдөө орон нутгийн эдийн засгийн идэвхгүй эмэгтэй хүн амын 26.4 нь гэрийн ажилтай эсвэл хүүхэд асардаг тул ажил хийдэггүй, хийх боломжгүй гэж хариулжээ.

Ийнхүү эдийн засгийн идэвхгүй байгаагийн гол шалтгаануудад ямар нэгэн сургуульд суралцдаг, өндөр настай буюу тэтгэвэрт байгаа хоёр орж байна.

Зураг 5. 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн амын бүтэц, шалтгаанаар



БҮЛЭГ V. АЖИЛ ЭРХЛЭЛТ**5.1 Тухайн үеийн ажиллагчид**

Ажиллах хүчний судалгаа нь Монгол Улсын хүн амын ажил эрхлэлтийн байдлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулах зорилгыг агуулсан. Судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдээс сүүлийн 7 хоногт эрхэлсэн ажил, түүнд хичнээн цаг зарцуулсан талаар асуусан. Түүнчлэн өвчтэй, амралтаа авсан, чөлөөтэй байсан, цаг агаарын бэрхшээл, ажил хаялт, хөдөлмөрийн маргаан болон бусад шалтгааны улмаас ажлын байртай боловч сүүлийн 7 хоногт ажлаа хийгээгүй хүмүүсийг дээрх асуултад хамруулсан. Сүүлийн 7 хоногт наад зах нь нэг цаг ажилласан, эсвэл сүүлийн долоо хоногт ажлын байртай боловч ямар нэг шалтгаанаар ажлаа түр хийгээгүй хүмүүсийг тухайн үед ажил эрхэлсэн гэж үзсэн.

Хүснэгт 18. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, хүйс, хот, хөдөөгөөр

Байршил/ бүс нутаг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	тоо	%	тоо	%	тоо	%
Хот	442,498	49.2	224,544	48.4	217,954	50.1
Хөдөө	456,434	50.8	239,236	51.6	217,198	49.9
Төв	162,186	18.0	84,566	18.2	77,620	17.8
Зүүн	66,573	7.4	36,298	7.8	30,275	7.0
Баруун	169,259	18.8	87,999	19.0	81,259	18.7
Хангай	235,910	26.2	119,709	25.8	116,200	26.7
Улаанбаатар	265,006	29.5	135,207	29.2	129,798	29.8
Дүн	898,932	100.0	463,780	100.0	435,152	100.0

Судалгааны дүнгээр улсын хэмжээнд нийт 898932 хүн тухайн үед ажил эрхэлж, түүнээс 51.6 хувь буюу 463,780 нь эрэгтэйчүүд, 48.4 хувь буюу 435,152 нь эмэгтэйчүүд байна. Хүснэгт 18-д сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн хүн амыг хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр харуулав. Тухайн үеийн ажиллагчдын 49.2 хувь нь хот, суурин газарт байгаа бөгөөд ажил эрхэлсэн хүний тоо бүс нутгуудаар ихээхэн ялгаатай байна. Нийт ажиллагчдын 29.5 хувь буюу 265,006 нь Улаанбаатар хотод ямар нэг ажил хийж байна. Ажиллагчдын тоог бүс нутгаар авч үзэхэд Хангайн бүсэд ажиллагчдын тоо илүү өндөр буюу 26.2 хувьтай байхад Зүүн бүс нутагт 7.4 хувьтай байна. Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тоо ойролцоо гарчээ.


5.2 Ажиллагчдын тоо, эдийн засгийн цйл ажиллагааны салбараар

Тухайн үеийн ажиллагчдын тоог, эдийн засгийн цйл ажиллагааны салбараар гаргаж Хүснэгт 19-д үзүүлээ. Нийт ажил эрхэлсэн хүн амын 41.6 хувь буюу 373681 түүний дотор 198537 эрэгтэй, 175145 эмэгтэйчүүд хөдөө аж ахуйн салбарт ажилласан байна. Мөн бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн засвар үйлчилгээний салбарт ажиллагчид нилээд хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл нийт ажил эрхлэгчдийн 12.9 хувь буюу 116275 нь энэ салбарт ажиллаж байна. Эдгээр салбарын дараа тээвэр, холбоо, агуулахын аж ахуй /7.7 хувь/, боловсролын салбар /6.7 хувь/, боловсруулах аж үйлдвэр /6.1 хувь/, үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад цйл ажиллагаа /4.4 хувь/, барилга /3.5 хувь/ зэрэг салбарууд илүү өндөр хувь эзэлж байна. Уул уурхайн олборлох аж үйлдвэр болон зочид буудал, зоогийн газрын салбарт нийт ажиллагчдын ердөө 2.5-2.6 хувь нь л ажиллажээ. Эдгээр салбарт нийт 22,0-23.0 мянган хүн ажилласан байна.

Хүснэгт 19. Тухайн цед ажил эрхэлсэн хүн амын тоо, хүйс, эдийн засгийн цйл ажиллагааны салбараар

Эдийн засгийн цйл ажиллагааны салбар	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	тоо	%	тоо	%
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	373,681	41.6	198,537	42.8	175,145	40.2
Загас агнуур	79	0.0	79	0.0	0	0.0
Уул уурхайн олборлох аж үйлдвэр	23,451	2.6	17,477	3.8	5,973	1.4
Боловсруулах аж үйлдвэр	54,386	6.1	25,921	5.6	28,464	6.5
Цахилгаан эрчим хүч, шатдаг хий, усан хангамж	13,362	1.5	9,026	1.9	4,336	1.0
Барилга	31,836	3.5	24,035	5.2	7,801	1.8
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн засвар үйлчилгээ	116,275	12.9	48,839	10.5	67,436	15.5
Зочид буудал, зоогийн газар	22,138	2.5	6,337	1.4	15,801	3.6
Тээвэр, холбоо, агуулахын аж ахуй	68,883	7.7	52,322	11.3	16,561	3.8
Санхүүгийн гүйлгээ хийх цйл ажиллагаа	8,655	1.0	3,450	0.7	5,205	1.2
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад цйл ажиллагаа	39,891	4.4	21,245	4.6	18,646	4.3
Төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн даатгал	27,367	3.0	19,664	4.2	7,704	1.8
Боловсрол	60,390	6.7	16,852	3.6	43,538	10.0
Эрүүл мэнд, нийгмийн халамж	30,352	3.4	6,401	1.4	23,951	5.5
Нийгэм бие хүнд үзүүлэх цйлчилгээ	22,218	2.5	10,560	2.3	11,658	2.7
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй	5,341	0.6	2,989	0.6	2,351	0.5
Олон улсын байгууллагын цйл ажиллагаа	628	0.1	46	0.0	582	0.1
Дүн, %		100.0		100.0		100.0
Тоо	898,932		463,780		435,152	

Зураг 6. Тухайн үеийн ажиллагчдын бүтэц, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар



5.3 Ажиллагчдын тоо, ажил мэргэжлийн ангиллаар

Хүснэгт 20-д тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоог ажил мэргэжлийн ангилалаар гаргаж харуулав. Нийтдээ 41714 хүн хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежерийн ажил хийсэн нь нийт ажил эрхэлж буй хүмүүсийн 4.6 хувьтай тэнцэж байна. Ажил хийсэн есөн хүний нэг нь мэргэжилтэн байна. Улсын хэмжээгээр нийт 101616 мэргэжилтэн байгаагийн дийлэнх буюу 69790 нь эмэгтэйчүүд байна. Нийт ажил хийсэн хүмүүсийн ихэнх буюу 366119 /40.7 хувь, үүний 172185 нь эмэгтэй/ нь хөдөө аж ахуйн болон загасны аж ахуйн холбогдолтой ажил эрхэлсэн байна.

Хүснэгт 20. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, ажил мэргэжлийн ангиллаар, хувиар

Ажил мэргэжлийн ангилал	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	тоо	%	тоо	%	тоо	%
Хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежер	41,714	4.6	25,273	5.4	16,441	3.8
Мэргэжилтэн	101,616	11.3	31,826	6.9	69,790	16.0
Инженер, техникийн ажилтан	35,818	4.0	14,416	3.1	21,401	4.9
Бичиг хэргийн туслах ажилтан	15,656	1.7	4,181	0.9	11,476	2.6
Үйлчилгээний ажилтан	129,850	14.4	49,537	10.7	80,312	18.4

Хүснэгт 20-ын цргэлжлэл

Ажил мэргэжлийн ангилал	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
ХАА, загасны аж ахуйн ажилтан	366,119	40.7	193,934	41.8	172,185	39.5
Үйлдвэрийн ба худалдааны ажилтан	88,047	9.8	56,594	12.2	31,453	7.2
Машин, тоног төхөөрөмжийн операторч, угсрагч	65,705	7.3	60,715	13.1	4,990	1.1
Энгийн ажил мэргэжил	52,882	5.9	26,269	5.7	26,614	6.1
Бусад	1,524	0.2	1,035	0.2	1,035	0.2
Дүн, %		100.0		100.0		100.0
Тоо	898,932		463,780		435,698	


Үйлчилгээний ажилтан нийт ажил эрхлэгчдийн 14.4 хувийг эзэлж байгаагийн дотор дийлэнх нь буюу 80312 нь эмэгтэйчүүд байна. Үйлдвэрийн ба худалдааны чиглэлээр 88047 хүн, машин, тоног төхөөрөмжийн операторч, угсрагчаар 65705 хүн ажилласан нь нийлээд сүүлийн 7 хоногт ажил хийсэн хүн амын 17.1 хувийг бүрдүүлжээ.

Ажил хийж буй арван хүний нэг нь үйлдвэрийн ба худалдааны ажилтан байна. Улсын хэмжээнд ажиллаж байгаа арван хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежерийн зургаа нь эрэгтэй хүн байхад, арван мэргэжилтний долоо нь эмэгтэй хүн байна.

5.4 Ажиллагчдын тоо, ажил эрхлэлтийн байдлаар

Ажил эрхлэлтийн байдлыг цалин хөлстэй ажил буюу хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч, иргэний гэрээгээр ажиллагч зэрэг нийт 6 ангилалд хуваав. Нийт ажиллагчдын арван хүний дөрөв нь гэрээгээр ажиллагч байгаа бөгөөд нийлээд 336791 (159306 эрэгтэй, 177485 эмэгтэй) хүн байна. Зураг 7-оос харахад нийт ажиллагчдын 32.8 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчид байгаа бол 4.7 хувь нь иргэний гэрээгээр ажиллаж байна. Ажиллагчдын гуравны нэгээс илүү хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, мөн дөрөвний нэг нь өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч байгаа бөгөөд энэ хоёр ангиллын хүмүүс нийлээд ажил эрхэлсэн хүн амын 60.0 гаруй хувийг эзэлж байна. Ажил хийсэн эмэгтэй хүн амын 36.1 хувь буюу 157228 нь өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч байна. Түүнчлэн ажил олгогч нарын эзлэх хувь бага буюу 0,7 хувьтай тэнцэж байна. Эндээс харахад жижиг, дунд оврын бизнесийн үйл ажиллагааны хэмжээ, тархалт бага байна.

Зураг 7. Тухайн үеийн ажиллагчдын ажил эрхлэлтийн байдлын бүтэц, хувиар



5.5 Ажиллагчдын тоо, байгууллагын харууллагын хэлбэрээр

Дараах хүснэгтээс нийт ажиллагчдын таван хүний нэг (151472) нь төрийн, төсөвт байгууллагад ажиллажээ. Төрийн, төсөвт байгууллагад ажиллагчдын арван хүний долоо нь хотод, гурав нь хөдөө орон нутагт ажиллаж байна.

Хүснэгт 21. Тухайн үед ажил эрхэлсэн 15, түүнээс дээш насны хүн амын тоо, аж ахуйн нэгж, байгууллагын төрөл, бүс нутгаар

Байгууллагын төрөл	Бүгд		Байршил/бүс нутаг						
	Тоо	%	Хот	Хөдөө	Төв	Зүүн	Баруун	Хангай	УБ
ХЭАА	1,773	0.2	0.3	0.1	0.1	0.2	0.1	0.1	0.4
Нөхөрлөл	1,671	0.2	0.3	0.1	0.1	0.1	0.0	0.1	0.4
Хоршоо	3,108	0.3	0.3	0.4	0.5	0.4	0.4	0.3	0.2
Хувьцаат компани	19,501	2.2	3.9	0.5	1.8	1.9	1.3	1.4	3.7
ХХК	126,650	14.1	25.9	2.7	11.7	4.7	3.3	4.6	33.3
УҮГ	25,433	2.8	4.6	1.1	5.5	2.3	0.3	2.1	3.5
Төрийн төсөвт байгууллага	151,472	16.9	23.4	10.5	18.4	15.3	14.4	11.6	22.5
Төрийн бус байгууллага	11,221	1.2	2.3	0.3	1.2	1.0	0.4	0.6	2.5
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	558,104	62.1	39.0	84.5	60.6	74.2	79.7	79.3	33.4
Дүн, %		100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	898,932		442,498	456,434	162,186	66,573	169,259	235,910	265,006

Хөдөө орон нутгийн нийт ажил эрхэлж буй хүн амын 84.5 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгчид бүрдүүлж байна. Улаанбаатар хотод ажиллагчдын хоёр хүний нэг нь төрийн, төсөвт байгууллагад, арван хүний гурав нь ХХК-д ажиллаж байна.

5.6 Давхар ажил эрхлэлт


Судалгаагаар үндсэн ажлын хажуугаар давхар ажил эрхэлж буй хүн амын талаар мэдээлэл цуглуулсан. Нийт 18055 хүн давхар ажил эрхэлж байгаа нь нийт ажил эрхэлж буй хүний 2.0 хувьтай л тэнцэж байна. Үндсэн ажлын цаг урт, хатуу хүнд цаг агаар, эдийн засгийн өнөөгийн бүтэц зэргийн улмаас давхар ажил эрхлэх бололцоо хязгаарлагдмал байж болзошгүй. Давхар ажил хийж буй хоёр хүний нэг нь үйлчилгээний ажилтан болон хөдөө аж ахуйн холбогдолтой ажил хийж буй хүмүүс байна. Түүнчлэн 3082 хүн мэргэжилтэнээр, 1325 хүн хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежерийн ажлыг давхар хашсан байна. Дээрх 4 мэргэжлийн хүмүүс давхар ажил эрхлэгчдийн дийлэнх хувь буюу 76.2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 22. Давхар ажил эрхэлж буй хүн амын тоо, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр

Ажил мэргэжлийн ангилал	Бүгд		Эрэгтэй	Эмэгтэй
	Тоо	%	%	%
Хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежер	1,325	7.3	10.2	2.7
Мэргэжилтэн	3,082	17.1	6.3	34.7
Инженер, техникийн ажилтан	620	3.4	2.6	4.8
Бичиг хэргийн туслах ажилтан	729	4.0	1.6	8.0
Үйлчилгээний ажилтан	2,022	11.2	13.1	8.1
ХАА, загасны аж ахуйн ажилтан	7,324	40.6	48.3	27.8
Үйлдвэрийн ба худалдааны ажилтан	999	5.5	6.8	3.5
Машин, тоног төхөөрөмжийн операторч, угсрагч	1,099	6.1	8.8	1.7
Энгийн ажил мэргэжил	854	4.7	2.3	8.7
Дүн	18,055	100.0	100.0	100.0

Давхар ажил эрхэлсэн хүн амыг, давхар ажил эрхэлсэн хугацаагаар авч үзвэл 1 жил хүртэлх хугацаанд давхар ажил эрхэлсэн хүн 30.0 хувь байхад, 1-2 жил болон 10-аас жил давхар ажил эрхэлсэн хүний тоо ойролцоо буюу 20.0 байна.

Зураг 8. Давхар ажил эрхэлсэн хүн амын бүтэц, давхар ажил эрхэлсэн хугацаагаар, хувиар



БҮЛЭГ VI. АЖИЛГҮЙДЭЛ

6.1. Нийтлэг зүйл

ОУХБ-аас зөвлөмж болгож буй ажилгүйдлийн талаарх тодорхойлолт нь ажлын байргүй, ажил хийх боломжтой, ажил хайж буй гэсэн 3 жишиг үзүүлэлтэнд тулгуурладаг. Хөдөлмөрийн зах зээл төлөвшөөгүй, зохион байгуулалтгүй, итгэл алдарсан ажилчид байдаг ядуу буурай орнуудад ажил хайх шалгуур үзүүлэлтийг нэг их хэрэглэдэггүй байна. Энэхүү АХС-нд ажиллах хүчинд хамаарагдах тухайн хугацаанд ажил, хөдөлмөр эрхлээгүй байгаа болон тухайн 7 хоногт ажил эрхлээгүй боловч ажил эрхлэхэд бэлэн байсан, ажил хөдөлмөр идэвхитэй хайсан хүмүүсийг ажилгүй хүн амд тооцсон. Түүнчлэн ажил хөдөлмөр эрхэлдэггүй ч ажил эрхлэх боломжтой, гэхдээ ажил олдохгүй гэж бодсон, эсхүл өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй мөн ажилд орох өргөдлөө өгсөн, ярилцлаганд орохоор хүлээж байгаа зэрэг шалтгааны улмаас ажил хайгаагүй хүмүүсийг ажилгүй хүн амд оруулж тооцов.

6.2. Ажилгүйдлийн тоо

Судалгааны дүнг тархаасан тооцоогоор сүүлийн 7 хоногт ажил хийх боломжтой, ажил хайсан ажилгүйдлийн тоо 114,533 байгаагийн 51.2 хувь буюу 58,691 нь эрэгтэй, 48.8 хувь буюу 55,842 нь эмэгтэйчүүд байна. Нийт ажилгүйдлийн дөрөвний гурав нь хот суурин газарт амьдарч байна.

Хүснэгт 23. Ажилгүйдлийн тоо, ажилгүйдлийн түвшин, хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр

Байршил /бүс нутаг	Ажилгүйдлийн тоо						Ажилгүйдлийн түвшин		
	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	%	%	%
Хот	86,697	75.7	43,990	75.0	42,707	76.5	16.4	16.4	16.4
Хөдөө	27,836	24.3	14,701	25.0	13,135	23.5	5.7	5.8	5.7
Төв	23,853	20.8	13,131	22.4	10,722	19.2	12.8	13.4	12.1
Зүүн	9,332	8.1	4,756	8.1	4,576	8.2	12.3	11.6	13.1
Баруун	13,759	12.0	7,260	12.4	6,499	11.6	7.5	7.6	7.4
Хангай	23,553	20.6	12,529	21.3	11,024	19.7	9.1	9.5	8.7
Улаанбаатар	44,036	38.4	21,015	35.8	23,021	41.2	14.2	13.5	15.1
Дүн	114,533	100.0	58,691	100.0	55,842	100.0	11.3	11.2	11.4

Ажилгүйдлийн тоог бүс нутгаар авч үзвэл таван ажилгүй хүний хоёр нь төв, хангайн бүсэд, харин нийт ажилгүйдлийн зөвхөн 8.0 орчим хувь нь зүүн бүсэд байна. Нийт ажилгүйдлийн 38.0 орчим хувь буюу 44,036 ажилгүй хүн Улаанбаатар хотод амьдарч байна. Ажилгүйдлийн хүйсийн бүтцийг бүс нутгаар нь авч үзэхэд зөвхөн Улаанбаатар хотод эмэгтэйчүүдийн нийт дүнд эзлэх хувь

эрэгтэйчүүдийнхээс 4.6 пунктээр илүү (эмэгтэйчүүд 52.3 хувь, эрэгтэйчүүд 47.7 хувь) байгаа бол бусад бүс нутагт эрэгтэйчүүдийн дүнд эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс 1.9-10.1 пунктээр илүү байна. Өөрөөр хэлбэл нийслэл хотод эмэгтэйчүүд, харин бусад бүс нутагт эрэгтэйчүүд ажилгүйдэлд илүү өртөж байна гэсэн үг.

Хүснэгт 24-д харуулсанаар нийт ажилгүйчүүдийн 61.1 хувийг 15-34 насны залуу хүмүүс, 32,6 хувийг 35-49 насныхан эзэлж байна Нийт ажилгүйчүүдийн 19.0 хувь нь 20-24 насныхан байгаа бөгөөд ажилгүйчүүдийн тоо цаашид буурч, 45-49 насанд 12,886 болж байна. Эндээс харахад залуу хүмүүс ялангуяа ажиллах хүчний эгнээнд шинээр элсэн орж буй хүмүүс ажилгүйдэлд илүүтэй өртөж байгаа ажээ. Ажилгүй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн насны бүтэц ерөнхийдөө төстэй байна.

Хүснэгт 24. Ажилгүйчүүдийн насны бүтэц, хувиар

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй %	Эмэгтэй %
	Тоо	%		
15-19	11478	10.0	9.9	10.1
20-24	21770	19.0	17.9	20.2
25-29	19397	16.9	15.6	18.3
30-34	17309	15.1	16.1	14.1
35-39	15630	13.6	13.2	14.2
40-44	12886	11.3	11.2	11.4
45-49	8795	7.7	7.7	7.7
50-54	4786	4.2	4.8	3.5
55-59	1689	1.5	2.7	0.2
60-64	638	0.6	0.8	0.3
65-69	68	0.1	0.1	0.0
70+	87	0.1	0.1	0.1
Дүн %		100.0	100.0	100.0
Тоо	114533		58691	55842

6.3. Ажилгүйдлийн түвшин


Судалгааны ажил эрхлээгүй хүн амаар тооцсон ажилгүйдлийн улсын дундаж түвшин 11.3 хувь байгаа бөгөөд хүйсээр задлан харвал эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 11.2 хувь, эмэгтэйчүүдийнх 11.4 хувьтай байна (Хүснэгт 6.1). Хот, суурин газарт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин улсын дундажтайгаа ижил байгаа бол хөдөө орон нутагт эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс ялимгүй өндөр байна. Ажилгүйдлийн түвшинг бүс нутгаар харахад төв, зүүн бүс Улаанбаатар хотын ажилгүйдлийн түвшин улсын дундажаас 1.0-2.9 пунктээр илүү байгаа бол баруун, хангайн бүсийн ажилгүйдлийн түвшин улсын дундажаас 2.2-3.8 пунктээр бага байна.

Судалгааны дүнгээр ажилгүйдлийн түвшинг насны бүлгээр нь авч үзэхэд 15-19(17.1 хувь), 20-24(17.6 хувь), 25-29(12.9 хувь) насны залуучуудын ажилгүйдлийн түвшин улсын дундажаас 1.6-6.3 пунктээр илүү байна. Ажил эрхлээгүй 15-29 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин бусад насны ажилгүйчүүдийн түвшингээс өндөр байгаа нь ажилгүйдлийн түвшинг насны бүлэг, хүйсээр тооцож харуулсан дараах зургаас (Зураг 6.1) тодорхой харагдаж байна. Ажилгүйдлийн түвшинг насны бүлэг, хүйсээр нь авч үзэхэд 15-29 насны эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин тухайн насны эрэгтэйчүүдийнхээс харьцангуй өндөр, 35-39 насны эмэгтэй,

эрэгтэйчүүдийнх ойролцоо, харин бусад насны бүлэгт эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс өндөр байна.

Ажилгүйдлийн түвшинг хүйсээр нь авч үзэхэд 15-19 насны охидын дунд ажилгүйдлийн түвшин 20.1 хувь байгаа нь хөвгүүдийнхээсээ 5.2 пунктээр, 20-24 насны эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс 2.8, 25-29 насны эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс 1.7 пунктээр тус тус илүү байна.

Зураг 9. Ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр



Эрэгтэйчүүдийн хувьд ажилгүйдлийн түвшин 15-24 нас хүртэл өссөнөө 25 наснаас эхлэн эргээд буурч байна.

6.4. Ажилгүйчүүдийн боловсролын түвшин


Судалгааны тархаалтын тооцоогоор нийт ажилгүйчүүдийн дөрвөн хүний нэг нь суурь боловсролтой, таван хүний хоёр нь бүрэн дунд боловсролтой хүмүүс байна. Ажилгүй арван хүний нэг нь дээд боловсрол эзэмшжээ. Энэ үзүүлэлтээр эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс бараг хоёр дахин их буюу 12.7 хувийг эзэлж байна. Гэтэл ажилгүйчүүдийн дунд боловсролгүй, бага боловсролтой хүний эзлэх хувь ердөө 8.1 хувь байна.

Хүснэгт 25. Ажилгүйдлийн боловсролын түвшин, хүйсээр, дүнд эзлэх хувиар

	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Боловсролгүй	1.9	1.8	2.0
Бага	6.3	8.0	4.3
Суурь	25.0	27.6	22.3
Бүрэн дунд	39.8	39.1	40.6
Мэргэжлийн анхан шатны	7.3	7.5	7.1
Дипломын дээд, тусгай мэргэжлийн дунд	10.0	9.1	11.0
Дээд	9.7	6.9	12.7
Дүн, %	100.0	100.0	100.0
Тоо	114,533	58,689	55,844

Боловсролгүй, бага боловсрол эзэмшсэн хүмүүс олдсон ажлыг голохгүй хийж байгаа тул тэдний дунд ажилгүйдлийн түвшин доогуур байгааг дараах зургаас үзэж болохоор байна.

Зураг 10. Ажилгүйдлийн түвшин, хүйс, боловсролын түвшнээр, хувиар



Дээд, мэргэжлийн анхан шатны, бүрэн дунд, суурь боловсролтой болон боловсролгүй эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээсээ 0.1-2.7 пунктээр өндөр байхад, бага болон дипломын дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин тухайн боловсролын түвшинтэй эмэгтэйчүүдээс 1.7-2.4 пунктээр илүү байна.

БҮЛЭГ III. БҮРЭН БУС АЖИЛ ЭРХЛЭЛТ

7.1 Нийтлэг зүйл

ОУХБ-ын 13-р Бага Хурлаас баталсан эдийн засгийн идэвхитэй хүн амын статистик тоо мэдээг гаргах тухай тогтоолд бүрэн бус ажил эрхлэлтийг дараах байдлаар тодорхойлжээ. Ажил мэргэжлийн түвшин, ур чадвартай (эзэмшсэн боловсрол, туршлага)-тай нь харьцуулахад доогуур түвшний ажил эсхүл тогтоосон норм (ажлын цаг)-д хүрэхгүй хэмжээнд ажил эрхэлж байвал бүрэн бус ажил эрхлэлт гэж үзнэ

Ажиллах хүчний судалгаагаар хүн амын ажил эрхлэлтийн талаар иж бүрэн мэдээлэлтэй болохын тулд бүрэн бус хөдөлмөр эрхлэлт байгаа эсэх, түүнд ямар хүмүүс өртөж байгаа талаар судалсан. Үүний тулд 15 ба түүнээс дээш насны тухайн үед ажил эрхэлж байгаа буюу сүүлийн долоо хоногт нэг ба түүнээс дээш цаг цалин, орлого бүхий ажил хийсэн хүмүүсээс одоо хийж буй ажлаасаа гадна нэмэлт ажил хийх, хүсэл боломж байсан эсэх, хэрэв байсан бол хэдий хугацаанд, нэмэгдэл ажлыг ямар арга замаар хайсан талаар мэдээлэл цуглуулсан.

7.2 Тухайн цөийн бүрэн бус ажил эрхлэлт


Хүснэгт 26-д нэмэгдэл ажил хийх боломжтой гэж хариулсан хүмүүсийг хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр харуулав. 15 ба түүнээс дээш насны 41.1 мянган хүн /22.5 мянган эрэгтэй, 18.6 мянган эмэгтэй/ нэмэгдэл ажил хийх боломжтой, улмаар өөрсдийгөө бүрэн бус ажил эрхэлж байна гэж үзжээ. Үүнээс харахад өөрсдийгөө бүрэн бус ажил эрхэлж байна гэж харьцангуй цөөхөн хүн үзэж байгаа бөгөөд нийт ажиллагчдаас нэмэлт ажил хайсан хүмүүсийн эзлэх хувь ердөө 6.6 хувь /эрэгтэйчүүдийнх 6.9 хувь, эмэгтэйчүүдийнх 6.3 хувь/ байна. Түүнчлэн бүрэн бус ажил эрхлэлтийн байдлыг хот, хөдөөгөөр авч үзэхэд хөдөө орон нутагт ажиллаж буй хүмүүс хотын хүмүүсээс, харин бүсээр авч үзэхэд зүүн бүсэд ажиллаж амьдарч буй хүмүүс бусад бүсийнхийг бодвол илүүтэйгээр нэмэгдэл ажил хийх боломжтой байна.

Хүснэгт 26. Нэмэгдэл ажил хийх боломжтой хүмүүс, хүйсээр, хот хөдөөгөөр, бүсээр

Байршил/бүс нутаг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хот	16883	41,1	9255	41,1	7629	41,1
Хөдөө	24188	58,9	13269	58,9	10919	58,9
Төв	12239	29,8	6564	29,1	5675	30,6
Зүүн	13872	33,8	7762	34,5	6110	32,9
Баруун	5244	12,8	3135	13,9	2109	11,4
Хангай	1359	3,3	680	3,0	679	3,7
Улаанбаатар	8357	20,3	4383	19,5	3975	21,4
Улсын дүн	41072	100.0	22524	100.0	18548	100.0

Нэмэгдэл ажил хийх боломжтой мөртлөө хийгээгүй шалтгааныг тодруулахад нэмэгдэл ажил олж чадахгүй байсан гэж 80.7 хувь нь хариулсан байна /Зураг 7.1/. Харин 4.1 хувь нь улирлын байдлаас шалтгаалсан, цаг агаар муу байсан, 8.8 хувь нь хөрөнгө санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй, 6.4 хувь нь машин тоног төхөөрөмж эвдэрсэн, түүхий эд, материал хүрэлцээгүй зэрэг бусад шалтгаанаар нэмэлт ажил хийгээгүй байна.

Зураг 11



Нийт нэмэгдэл ажил хийх боломжтой байсан хүмүүсийн ажил хайсан хэлбэрийг сонирхвол 51.3 хувь ажил хайх ямар нэгэн оролдлого хийгээгүй, 18.5 хувь нь найз нөхөд ба хамаатнуудаасаа тусламж хүссэн, 8.5 хувь нь мэдээллийн хэрэгслээр хайсан, 8.2 хувь нь хувийн бизнес эрхлэх газар, тоног төхөөрөмж, санхүүгийн эх үүсвэр хайсан байна. Харин Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Хэлтэст бүртгүүлсэн, ажил олгогчдод өргөдөл өгсөн, ажлын яармагуудад очиж бүртгүүлсэн зэрэг нэлээд идэвхитэй арга, хэлбэрүүд 1.2-3.8 хувийг эзэлж байна.

Ажил хайсан хэлбэрийг хот, хөдөөгөөр авч үзвэл нэлээд ялгаатай үр дүн гарч байна. Тухайлбал, нийт нэмэгдэл ажил хайсан хүмүүсийн 41.1 хувийг хотынхон, 58.9 хувийг хөдөөнийхөн эзэлж байна. Хотын нэмэгдэл ажил хайгчдыг ажил хайсан хэлбэрээр нь хөдөөнийхэнтэй харьцуулахад ХХҮХ-т бүртгүүлсэн нь хотод 4.7 хувь байхад хөдөөд 2.2 хувь, мэдээллийн хэрэгслээр хайсан нь хотод 7.0 хувь байхад хөдөөд 1.5 хувь, ажил олгогчдод өргөдөл өгсөн нь хотод 1.1 хувь байхад хөдөөд 4.0 хувь, хувийн бизнес эрхлэх санхүүгийн эх үүсвэр хайсан нь хотод 13.8 хувь байхад хөдөөд 4.2 хувь байна. Харин нэмэгдэл ажил хайх ямар нэгэн оролдлого хийгээгүй хүмүүс хотод 33.5 хувь байхад хөдөөд 63.8 хувьтай байна.

Хүснэгт 27-д нэмэгдэл ажил хийх боломжтой байсан хугацааг байршил, бүс нутгаар харуулав.

Хүснэгт 27. Нэмэгдэл ажил хийх боломжтой байсан хугацаа, байршил, бүс нутгаар

Бололцоотой хугацаа	Бүгд	Байршил/ бүс нутаг						
		Хот	Хөдөө	Төв	Зүүн	Баруун	Хангай	УБ
1 сараас бага	8,8	10,3	7,9	9,0	5,3	14,2	13,4	10,3
1 - 2 сар	10,6	12,2	9,5	7,3	11,6	16,7	0,9	11,6
3 -6 сар	20,3	12,5	25,8	18,2	27,8	11,6	29,7	14,9
7-11 сар	6,6	6,8	6,4	2,7	8,1	6,2	4,3	10,3
1 -2 жил	23,5	22,8	23,9	17,0	26,0	32,7	9,4	25,2
3 ба түүнээс дээш жил	30,2	35,3	26,6	45,7	21,2	18,6	42,3	27,7
Дүн %	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0
Тоо	41 072	16 883	24 188	12 239	13 872	5 244	1 359	8 357


Улсын хэмжээнд нийт нэмэлт ажил хийх боломжтой байсан хүмүүсийн талаас илүү хувь нь 1 ба түүнээс дээш жилийн хугацаанд нэмэгдэл ажил хийх боломжтой байсан байна.

7.3 Нэмэгдэл ажил хийх боломжгүй шалтгаан

Тухайн үед буюу сүүлийн долоо хоногт ажилласан 15 ба түүнээс дээш насны 898.9 мянган ажиллагчдын 857.9 мянга буюу 95.4 хувь нь нэмэгдэл ажил хийх боломжгүй байжээ. Үүний 441.3 мянга буюу 51.4 хувь эрэгтэйчүүд, 416.6 мянга буюу 48.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Зураг 7.2-оос харахад нэмэгдэл ажил хийх боломжгүй байсан хүмүүсийг хот хөдөөгөөр ялгаж үзэхэд онцын зөрүүгүй байна. Харин бүс нутгаар авч үзэхэд хангайн бүсэд бусад бүсүүдээс харьцангуй олон хүмүүс нэмэгдэл ажил хийх боломжгүй гэж хариулсан байна. Тухайлбал, хангайн бүсэд нэмэгдэл ажил хийх боломжгүй хүмүүсийн тоо төв болон баруун бүсүүдээс 2.4 дахин, зүүн бүсээс 3.4 дахин, нийслэл Улаанбаатар хотоос 3.9 дахин бага байна.

Зураг 12

15 ба түүнээс дээш насны нэмэгдэл ажил хийх боломжгүй байсан хүний тоо, хүйс, байршил, бүс нутгаар /мян.хүн/



Хүснэгт 28-д нэмэгдэл ажил хийх боломжгүй байсан шалтгааныг насны бүлэг болон хот хөдөөгөөр харуулав. Улсын хэмжээнд нэмэгдэл ажил хийх боломжгүй байсан хүмүүсийн 93.4 хувь нь хийх ажил хангалттай гэж үзсэн байхад үлдсэн нь гэрийн ажил хийсэн, суралцсан, өвчтэй байсан, амралттай, жирэмсэн, хүүхдээ асарсан болон бусад шалтгаантай байна.

Монгол Улсад хуулиар мөрдөгдөж буй хөдөлмөрийн нас буюу 16-59 насны 769.8 мянган хүний 93.5 хувь нь хийх ажил хангалттай, 4.1 хувь гэрийнхээ ажлыг хийдэг, 0.7 хувь нь жирэмсэн / хүүхдээ асарсан, 0.6 хувь суралцагч байна.

Хүснэгт 28. Нэмэгдэл ажил хийх боломжгүй байсан шалтгаан, насны бүлэг, байршлаар

Насны бүлэг, байршил	Бүгд	Хийх ажил хангалттай	Гэрийнхээ ажлыг хийдэг	Суралцагч	Түр өвчтэй байсан	Амралттай байсан	Жирэмсэн / хүүхдээ асарсан	Бусад
	Тоо	%	%	%	%	%	%	%
15-19	52 454	5,5	7,6	80,4	0,0	1,1	0,2	9,1
20-24	96 480	11,3	10,2	9,9	10,1	8,3	13,0	12,8
25-29	123 895	14,4	16,9	2,0	7,2	11,7	28,8	13,0
30-34	132 683	15,7	14,4	1,4	0,0	9,8	18,7	14,1
35-39	123 124	14,5	13,2	1,9	19,9	15,8	20,6	11,0
40-44	118 599	14,0	11,4	0,6	18,7	12,7	17,1	12,0
45-49	96 073	11,3	9,6	0,9	19,4	29,1	0,2	15,2
50-54	58 009	6,8	8,0	0,0	24,4	8,0	0,1	1,7
55-59	29 462	3,4	5,2	1,4	0,4	1,8	0,7	3,1
60-64	13 890	1,6	1,9	1,4	0,0	0,0	0,0	2,9
65-69	6 903	0,8	0,9	0,0	0,0	1,6	0,7	5,0
70+	6 288	0,8	0,5	0,0	0,0	0,0	0,0	0,0
Хот	425 614	51,1	20,2	17,0	60,4	55,7	54,5	49,9
Хөдөө	432 246	48,9	79,8	83,0	39,6	44,3	45,5	50,1
Улсын дүн	857 860	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0

Хүснэгт 28-д шалтгаан бүрийг насны бүлэг болон хот, хөдөөгөөр ялган үзүүлсэн байдлаас харахад хийх ажил хангалттай гэж хариулсан хүмүүсийн 51.1 хувь нь хотод, 48.9 хувь нь хөдөөд амьдарч байна. 25-44 насныхан нэмэгдэл ажил хийх боломжгүй байсан хүмүүсийн 58.1 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд шалтгаанаар авч үзэхэд энэ насныхан суралцаж байсан шалтгаанаас бусад бүх шалтгаанд дийлэнх хувийг эзэлж байна.

БҮЛЭГ VIII. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ УЛИРЛЫН ХЭЛБЭЛЗЭЛ

8.1. Нийтлэг зүйл

Тус судалгааны нэг зорилго нь ажиллах хүчний улирлын хэлбэлзлийг үндэсний, хэмжээнд болон хот, хөдөөгийн түвшинд судлан гаргах явдал юм. Энэ зорилгын хүрээнд нийт түүврийн хэмжээг 4 улирлаар бүлэглэн тэнцүү хувааж, түүврийн сонголтыг 3 сар тутам буюу улирал бүрээр хангалттай хэмжээнд хийсэн болно. Нэг улиралд 3072 өрхийг түүвэрлэн хамруулж, нийт дөрвөн улирлын тоо мэдээг нэгтгэн үндсэн үзүүлэлтүүдийг тооцсоноос гадна улирал тус бүрээр гаргасан үндсэн үзүүлэлтүүдийг энэхүү бүлэгт оруулж танилцуулж байна. Судалгаанд нийт 12886 өрхийн 47190 гишүүнийг хамруулж, судалгааны мэдээллийг 2006 оны 7 сараас 2007 оны 6 сарыг дуусталх хугацаанд 4 улирлаар цуглуулав.

Ажиллах хүчний судалгааны хугацаа цаг тооллын улирлын хугацаатай таарахгүй бөгөөд судалгааны эхний буюу 1 дүгээр улиралд 2006 оны 7-9 –р сар, 2 дугаар улиралд 2006 оны 10-12-р сар, 3 дугаар улиралд 2007 оны 1-3-р сар, харин судалгааны сүүлийн буюу 4 дүгээр улиралд 2007 оны 4-6-р сарууд хамрагдсан болно.

8.2. Эдийн засгийн идэвхитэй хүн ам

Эдийн засгийн идэвхитэй хүн ам буюу ажиллах хүчийг улирлаар тооцож үзэхэд дөрвөн улирлын турш эдийн засгийн идэвхитэй хүн ам нэг их өөрчлөгдөлгүйгээр ойролцоогоор 1.0 сая орчим байна.


Хүснэгт 29 . 15, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхи, улирлын тооцоогоор

	Судалгааны хугацаанд		1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	2006.VII-2007.VI	VII-IX	X-XII	I-III	IV-VI	
Ажиллах хүч	1013465	975129	979607	1054947	1044177	
Эрэгтэй	522471	498516	504661	548461	538244	
Эмэгтэй	490994	476613	474946	506486	505933	
АХОТ, 15+ (%)	62.7	64.8	61.7	62.6	62.1	
Эрэгтэй	67.5	69.5	65.7	67.6	67.4	
Эмэгтэй	58.3	60.4	57.8	58.0	57.2	
Хот	54.1	55.2	54.3	52.7	54.1	
Хөдөө	76.0	81.3	74.3	75.8	73.5	
Эдийн засгийн идэвхигүй хүн амын тоо	602020	530539	609374	629934	638230	
Эрэгтэй	251211	218486	262891	263191	260276	
Эмэгтэй	350809	312053	346483	366743	377954	
Хот	449236	427210	459620	454808	455309	
Хөдөө	152783	103329	149754	175126	182921	

Намрын цагт буюу судалгааны 1 дүгээр улиралд эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо хамгийн бага буюу 975,1 мянга байснаа дараагийн 2 улиралд өсч, 3 дугаар улирал гэхэд 1,055 мянга болжээ.

Эдийн засгийн идэвхигүй хүн ам судалгааны 1 дүгээр улирлаас эхлэн 4 дүгээр улирал хүртэлх хугацаанд 10,8 мянгаар нэмэгдсэнээс харахад зун, намрын улиралд эдийн засгийн идэвхитэй байсан хүмүүсийн тоо бусад улирлынхаас илүү байгаатай холбоотой байж болох юм.

Зураг 13



Зураг 13-аас харахад ажиллах хүчний оролцооны түвшин(АХОТ) судалгааны 1 дүгээр улиралд хамгийн өндөр буюу 64.8 хувь, 2 дугаар улиралд хамгийн бага буюу 61.7 хувь, харин бусад улирлуудад ойролцоогоор 62.0 хувьтай байна.

Эдийн засгийн идэвхитэй хүн амын тоон дахь хэлбэлзэл нь ажил эрхэлсэн хүн амын тооны өөрчлөлттэй холбоогүй бөгөөд ажилгүйчүүдийн тоо буурсан нь ажил эрхэлсэн хүмүүсийн тоог нэмэгдэхэд хүргэжээ. Ажиллах хүчний нэг хэсэг буюу эдийн засгийн идэвхитэй хүмүүс жилийн хэсэг хугацаанд эдийн засгийн идэвхгүй болж, тэдний орыг өөр хүмүүс эзэлж байж ч болох талтай. Гэхдээ л өвлийн улирал дуусахтай зэрэгцэн улирлын чанартай эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх нөхцөл бүрдсэнээр ажилгүй хүн амын нэг хэсэг ажил эрхлэн энэ нь ажил эрхлэгч хүн амын тоог нэмэгдүүлж байгаа нь тодорхой байна.

8.3. Ажиллагчдын тоо

Хүснэгт 30-д ажиллах хүчний эрэлт хэрэгцээ нь улирлаар хэлбэлзэж буйг харуулж байна. Судалгааны 1 дүгээр улиралд 861982 хүн ажил хийсэн бол 4 дүгээр улирал буюу 4-6 сард энэ тоо 89265-аар өсч, 951,247-д хүрсэн нь хөдөө орон нутаг ажил эрхэлсэн хүний тоо нэмэгдсэнтэй холбоотой.


Ажиллах хүчний эрэлт хэрэгцээ улирлаар өсөх явдал хөдөө орон нутаг ажиглагдаж судалгааны 1 дүгээр улиралд ажиллагчдын тоо 426,991 байснаа 3 дугаар улиралд 509,107 болтол нэмэгдсэн байна.

Хүснэгт 30. 15, түүнээс дээш насны ажил эрхэлсэн хүн амын тоо, улирлаар

	Судалгааны	1-р	2-р	3-р	4-р
	хугацаанд	улирал	улирал	улирал	улирал
	2006.VII-2007.VI	VII-IX	X-XII	I-III	IV-VI
Тухайн үеийн ажиллагчдын тоо	898932	861982	855910	926590	951247
Эрэгтэй	463780	443593	440959	481403	489164
Эмэгтэй	435152	418389	414951	445187	462083
Хот	442498	434991	451642	417483	465876
Хөдөө	456434	426991	404268	509107	485371
Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар					
Хөдөө аж ахуй	373760	373704	320988	404858	395493
Үйлдвэрлэл	123035	123133	115185	110014	143809
Үйлчилгээ	402137	365145	419737	411718	411944
Ажиллагчдын тоо, ажил эрхлэлтийн байдлаар					
Гэрээгээр ажиллагч	336791	320618	329174	340105	357269
Ажил олгогч	5953	6105	5546	6698	5462
Хоршооллын гишүүн	488	33	984	435	500
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	305977	292057	284640	317771	329441
Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч	249723	243169	235566	261581	258575

Манай улсын хүн амын ажил эрхлэлт улирлаар нилээн хэлбэлзэлтэй байдаг хандлагыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нь ангилан гаргасан дараах зургаас харж болно. Судалгааны 1 дүгээр улирал буюу 7-9 саруудад манай орны хувьд хөдөө аж ахуйн салбар дахь эдийн засгийн үйл ажиллагаа (мал аж ахуй, газар тариалан, ойн аж ахуйн холбогдолтой) өргөжих таатай боломж бүрдэж, өвлийн улирлаас зун, намрын улирлын хүн амын ажил эрхлэлтийн хэлбэлзэл их байгааг харуулж байна.

Зураг14. Ажиллагчдын тоо, эдийн засгийн цйл ажиллагааны салбар, улирлаар




Судалгааны 2 дугаар улирлын ХАА-н салбарын ажиллагчдын тооны бууралтанд ажил, сургуулийнхаа зуны амралтаараа хөдөө орон нутагт ирж мал аж ахуй, газар тариалан, ойн аж ахуйн холбогдолтой улирлын чанартай эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байсан хүүхэд, залуус хичээл сургууль, ажил төрөлдөө орсон нь голлон нөлөөлсөн гэж үзэж байна. Мөн энэ салбарын ажиллагчдын тооны бууралт нь тухайн улирлын үйлчилгээний салбарын ажиллагчдын тоо огцом өсөхөд нөлөөлсөн байж болзошгүй юм.

Харин үйлдвэрлэлийн салбарт ажиллагчдын тоонд онцын их өөрчлөлт ажиглагдаагүй нь энэ салбарт ажил эрхлэлт улирлаар нэг их хэлбэлздэггүйг харуулж байна.

15 ба түүнээс дээш насны хүн амын ажил эрхлэлтийн түвшин хөдөө орон нутагт хот суурин газрынхаас 10 гаруй пунктээр илүү байгаа нь хөдөө аж ахуйн салбарт хүмүүс олноороо ажиллаж байгаатай холбоотой. Судалгааны 1,4 дүгээр улирал буюу 4-9 сарын хооронд хүн амын ажил эрхлэлтийн түвшин хамгийн өндөр хувьтай байна.


Зураг 15. 15, түүнээс дээш насны хүн амын ажил эрхлэлтийн түвшин, хот, хөдөө, улирлаар



8.4. Ажил эрхлээггүй хүн ам

Судалгаагаар ажилгүйдлийн төлөв байдлын талаар мэдээлэл нэмж цуглуулан ажилгүйдлийн үзүүлэлтүүд, цар хүрээг улирлын хэлбэлзлээр тооцсон юм. Хавар, зуны улиралд ажилгүйчүүдийн тоо, ажилгүйдлийн түвшин буурчээ. Судалгааны 1 дүгээр улиралд ажилгүйчүүдийн тоо, ажилгүйдлийн түвшин 113,147 буюу 11.6 хувь байснаа буурч, 4 дүгээр улиралд 92,930 буюу 8.9 хувь болсон байна. Ажилгүйдлийн түвшинг буурахад ажиллах хүчний улирлын хэлбэлзэл нөлөөлсөн.

Зураг 16. Ажилгүйдлийн түвшингийн улирлын тооцоо, хүйсээр, хувиар



Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажилгүйдлийн түвшин улирал бүрт онцын их ялгаагүй ойролцоо байгаа бөгөөд зөвхөн 4 дүгээр улирал буюу судалгааны 4-6 сард эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс 0.4 пунктээр илүү байна. Харин хот, хөдөөгөөр авч үзвэл хөдөөд ажилгүйдлийн түвшин хот суурин газрынхаас ойролцоогоор 10 пунктээр доогуур байгаа юм.

Хүснэгт 31. 15, түүнээс дээш насны ажилгүйдчүүдийн тоо, улирлаар

	Судалгааны хугацаанд	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	2006.VII-2007.VI	VII-IX	X-XII	I-III	IV-VI
Ажилгүйдчүүдийн тоо	114533	113147	123696	128400	92930
Эрэгтэй	58691	54923	63701	67100	49080
Эмэгтэй	55842	58224	59995	61300	43850
Хот	86697	90740	94672	90200	71169
Хөдөө	27836	22407	29024	38200	21761
Ажилгүйдлийн түвшин, %	11.3	11.6	12.6	12.2	8.9
Эрэгтэй	11.2	11.0	12.6	12.2	9.1
Эмэгтэй	11.4	12.2	12.6	12.1	8.7
Хот	16.4	17.3	17.3	17.8	13.3
Хөдөө	5.7	5.0	6.7	7.0	4.3

БҮЛЭГ IX. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ 2002-2003, 2006-2007 ОНЫ СУДАЛГААНУУДЫН ҮНДСЭН ҮР ДҮНГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

9.1. Нийтлэг зүйл

Монгол Улсад 2002-2003 онд анх удаа “Ажиллах хүчний судалгаа (АХС)”-г олон улсын жишиг аргачлалын дагуу улирлаар явуулсан нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний суурь судалгаа болсон билээ. Энэхүү судалгаа нь хүн амын ажил эрхлэлтийн талаар Олон улсын хөдөлмөрийн байгууллага(ОУХБ)-аас гаргасан нийтлэг тодорхойлолт, арга зүйг ашиглан хүн амын эдийн засгийн идэвхийг сүүлийн 7 хоногийн буюу тухайн үеийн, сүүлийн 12 сарын буюу байнгын идэвхийн аргачлалаар тооцох замаар хүн амын ажил эрхлэлтийн байдлыг тодорхойлон, хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлийн холбогдолтой үзүүлэлтүүдийг улирлын нөлөөллийг нь тусган тооцож гаргасан.

2004 онд “Хүн амын ажил эрхлэлтийн түүвэр судалгааг улирал тутам явуулж байх”-аар Монгол Улсын “Статистикийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэх, нөгөө талаас хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаар нарийвчлан тогтмол судлах зорилгоор АХС-г өмнө нь нэг удаа явуулсан туршлагад үндэслэн, ОУХБ-аас гаргасан нийтлэг тодорхойлолт, арга зүйн дагуу 2006-2007 оны АХС-г явуулсан болно.

Монгол Улсын хүн ам, өрхийн 2005 оны жилийн эцсийн мэдээнд үндэслэн түүврийн хүрээг тогтоосон бөгөөд судалгаанд нийт 12886 өрхийн 47190 гишүүнийг хамруулж, судалгааны мэдээллийг 2006 оны 7 сараас 2007 оны 6 сарыг дуустал хугацаанд 4 улирлаар цуглуулав.

Ажиллах хүчний судалгааны хугацаа цаг тооллын улирлын хугацаатай таарахгүй бөгөөд судалгааны эхний буюу 1 дүгээр улиралд 2006 оны 7-9 –р сар, 2 дугаар улиралд 2006 оны 10-12-р сар, 3 дугаар улиралд 2007 оны 1-3-р сар, харин судалгааны сүүлийн буюу 4 дүгээр улиралд 2007 оны 4-6-р сарууд хамрагдсан болно.

9.2. Хүн ам зүйн үзүүлэлтүүд

2006-2007 оны АХС-ны түүврийн тархаалтын тооцоогоор 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа иргэдийг оруулаад Монгол Улсын нийт хүн ам 2.4 сая байна. Энэ тооцоонд дотуур байр, эмнэлэг, цэргийн хуаран, засан хүмүүжүүлэх газар зэрэг нийтийн байранд байгаа хүмүүсийг хамруулаагүй болно. 2002-2003 оны АХС-ны тооцоогоор 2,403 мянга, засаг захиргааны бүртгэлд үндэслэн гаргадаг хүн амын ажил эрхлэлтийн 2007 оны жилийн эцсийн тайлангийн дүнгээр 2,602 мянга байсан байна.

Судалгааны дүнгээр улсын хэмжээнд нийт 597.2 мянган өрх байгаа бөгөөд өмнөх оны судалгааны дүнтэй харьцуулахад 5 хувь буюу 28.4 мянгаар нэмэгдсэн дүн гарлаа. Өрхийн ам бүлийн тоо 4.0 байгаа нь өмнөх судалгааныхаас арай бага ойролцоо байлаа.


Хүснэгт 32. Өрх, хүн амын тоо, АХС-ны дүнгээр

	Ажиллах хүчний судалгаа		2006-2007
	2002-2003	2006-2007	2002-2003
Өрхийн тоо	568800	597218	105.0
Нийт хүн амын тоо*	2402800	2415332	100.5
Өрхөөс гадуур амьдарч байгаа хүний тоо	174000	178000	102.3
Судалгаанд хамрагдсан хүн амын тоо	2228800	2237332	100.4
Үүнээс: насны бүлгээр			
0-14	689600	621847	90.2
15-64	1453800	1530095	105.2
65 ба дээш	85400	85390	100.0
Өрхийн ам бүлийн дундаж тоо	4.2	4.0	96.3

* 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа өрхийн гишүүдийг оруулсан

Судалгааны үр дүнгийн тархаалтын тооцоогоор нийт хүн амын 27.8 хувийг 0-14 насны хүүхэд, 68.4 хувийг 15-64 насны, 3.8 хувийг 65 ба түүнээс дээш насны хүмүүс эзэлж байна. Хүн амын насны бүтцийг хүн ам, орон сууцны сүүлийн 3 тооллого болон 2002-2003 оны АХС-ны насны бүтэцтэй харьцуулж үзэхэд ажиглагдаж байгаа гол өөрчлөлт болох сүүлийн 30 гаруй жилд 15-64 насны хүн амын эзлэх хувь тогтвортой нэмэгдэж, харин 0-14 насны хүүхдүүдийн эзлэх хувь буурч байгаа хандлага энэ судалгааны дүнгээр ч бас харагдаж байна.

Зураг 17. Хүн амын насны бүтэц, 1979,1989,2000 оны ХАОСТ, 2002-2003, 2006-2007 оны АХС-ны дүнгээр



9.3. Эдийн засгийн идэвхитэй хүн ам


2006-2007 судалгааны түүврийн тархаалтын тооцоогоор 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо 1615.4 мянга болж, 2002-2003 оны судалгаатай харьцуулахад 5.0 хувь буюу 76.2 мянгаар өссөн байна.

Хүснэгт 33 . 15, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхи, АХС-ны дүнгээр

	Ажиллах хүчний судалгаа		2006-2007 2002-2003	%
	2002-2003	2006-2007		
15, түүнээс дээш насны хүн ам	1539.2	1615.4	105.0	
Эдийн засгийн идэвхитэй хүн ам	1004.8	1013.4	100.9	
Ажиллагчид	862.5	898.9	104.2	
Ажилгүйчүүд	142.3	114.5	80.5	
Эдийн засгийн идэвхигүй хүн ам	534.4	602.0	112.6	

Харин эдийн засгийн идэвхитэй хүн ам буюу ажиллах хүчинд энэ хоёр судалгаанд ойролцоогоор 1.0 сая орчим хүн хамрагдаж байна. Судалгааны дүнгээр өмнөх судалгаатай харьцуулахад ажиллагчдын тоо 4.2 хувь өссөн ч гэсэн ажилгүйчүүдийн тоо 19.5 хувиар буурсан нь эдийн засгийн идэвхитэй хүн амын өсөлт бага буюу 0.9 хувь гарахад нөлөөлжээ.

Зураг 18. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр, АХС-ны дүнгээр



2006-2007 оны АХС-ны дүнгээр ажиллах хүчний оролцооны улсын дундаж түвшин 62.7 хувьд хүрч, 2002-2003 оны судалгааны дүнгээс 2.6 пунктээр буурсан нь 15 ба түүнээс дээш насны хүн ам өмнөх оны судалгаанаас 5.0 хувиар өссөнтэй холбоотой юм. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн АХОТ түвшин мөн 2.2-2.8 пунктээр буурсан байна.

Эдийн засгийн идэвхигүй хүн амын тоо 602.0 мянгад хүрч, 2002-2003 оны судалгааны дүнтэй харьцуулахад 12.6 хувь буюу 67.6 мянгаар өссөн байна.

9.4. Ажиллагчдын тоо

Судалгааны дүнгээр 15 ба түүнээс дээш насны ажил эрхэлсэн хүний тоог 2002-2003 оны АХС-тай харьцуулахад 4.2 хувиар өсч, 898.9 мянгад хүрчээ (Хүснэгт 34). Нийт ажил эрхэлсэн хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь өмнөх судалгаатай харьцуулахад 0.4 пунктээр нэмэгдсэн байна. Ажиллагчдын тоог хот, хөдөөгөөр авч үзэхэд хот суурин газарт ажиллагчдын тоо харьцангуй өсч (12.8 хувь) 442.5 мянгад хүрсэн бол, хөдөө орон нутагт ажиллагчдын тоо 456.4 мянгад хүрч 2002-2003 оны түвшингээс 2.9 хувиар буурчээ.

Хүснэгт 34. 15, түүнээс дээш насны ажил эрхэлсэн хүн амын тоо, 2002-2003, 2006-2007 оны АХС-ны дүнгээр


	Ажиллах хүчний судалгаа		2006-2007 2002-2003	%
	2002-2003	2006-2007		
Тухайн үеийн ажиллагчдын тоо	862500	898932	104.2	
Эрэгтэй	448900	463780	103.3	
Эмэгтэй	413600	435152	105.2	
Хот	392300	442498	112.8	
Хөдөө	470200	456434	97.1	
Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар				
Хөдөө аж ахуй	402700	373760	92.8	
Үйлдвэрлэл	102900	123035	119.6	
Үйлчилгээ	356900	402137	112.7	
Ажиллагчдын тоо, ажил эрхлэлтийн байдлаар				
Гэрээгээр ажиллагч	338600	336791	99.5	
Ажил олгогч	5500	5953	108.2	
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	303300	305977	100.9	
Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч	215000	249723	116.2	

Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар болох хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдын тоо харьцангуй буурсан (7.2 хувь) нь хөдөө орон нутагт ажиллагчдын тоо буурахад нөлөөлсөн байна. Харин үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарт ажиллагчдын тоо 12.7-19.6 хувиар өссөн нь хот суурин газарт ажиллагчдын тоо өссөнтэй холбоотой байж болох юм.

2006-2007 оны ажиллагчдын эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбарын бүтцийг 2002-2003 оны судалгааны дүнтэй харьцуулан авч үзэхэд нийт ажиллагчдын дотор хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдын эзлэх хувь 5.1 пунктээр


буурч, харин үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарт ажиллагчдын эзлэх хувь 1.8-3.3 пунктээр тус тус өссөн байна (Зураг 19).

Зураг 19. Ажиллагчдын эдийн засгийн цүйл ажиллагааны салбарын бүтэц, 2002-2003, 2006-2007 оны АХС-ны дүнгээр



Ажиллагчдын ажил эрхлэлтийн байдлын бүтцийг ажиллах хүчний 2 судалгаагаар харьцуулан харахад 2006-2007 онд нийт ажиллагчдын дотор өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогчдын эзлэх хувь 2002-2003 оныхоос 2.9 пунктээр нэмэгдэж, харин хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон гэрээгээр ажиллагчдын эзлэх хувь 1.2-1.8 пунктээр тус тус буурсан байна (Зураг 20).

Зураг 20. Ажиллагчдын ажил эрхлэлтийн байдлын бүтэц, 2002-2003, 2006-2007 оны судалгааны дүнгээр




2006-2007 оны судалгааны дүнгээр 15 ба түүнээс дээш насны хүн амын ажил эрхлэлтийн улсын дундаж түвшин 83.6 хувь болж, өмнөх судалгааны дундаж түвшнээс 2.3 хувиар өссөн байна. Хөдөө орон нутгийн хүн амын ажил эрхлэлтийн түвшин 7.3 хувиар өсч 97.3 хувьд хүрсэн бол, хот хот суурин газрынх 2.3 хувиар өсч 83.6 хувьтай байна.

9.5. Ажил эрхлээггүй хүн ам

Судалгаагаар ажилгүйдлийн улсын дундаж түвшин 14.2 хувь гарсан нь өмнөх оны судалгаанаас 2.9 пунктээр илүү байна (Зураг 21).

Зураг 21. Ажилгүйдлийн түвшин, хүйсээр, 2002-2003, 2006-2007 оны судалгааны дүнгээр, хувиар



Мөн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 14.1-14.2 хувьд хүрч, 2002-2003 оныхоос 2.7-3.0 пунктээр илүү байна.

2006-2007 оны судалгааны дүнгээр ажиллагчдын тоо 4.2 хувиар өссөн ч гэсэн, тухайн хугацаанд ажилгүйчүүдийн тоо 19.5 хувиар буурсан нь ажилгүйчүүдийн түвшинг өсгөхөд нөлөөлсөн байна.

БҮЛЭГ X. ТҮҮВРИЙН АЛДАА

10.1 Нийтлэг зүйл

Судалгааны түүвэрлэлтийн нэгж нь өрх юм. *Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ.* Өрхийн ам бүлийн тоонд тухайн өрхөд 6 сараас илүү хугацаагаар эзгүй байгаа (хугацаат цэргийн албан хаагч, оюутан сурагчид, гадаадад ажиллаж амьдарч байгаа болон цагдан хоригдож байгаа) иргэдийг өрхийн гишүүнд тооцохгүй.

10.2 Түвшэрлэлт

Ажиллах хүчний түүвэр судалгааны бүлэглэлтийг засаг захиргааны нэгж буюу бүх аймгууд, Улаанбаатар хотын дүүргүүд байхаар хийсэн. Энэ нь бодлого боловсруулагчдад хөдөлмөрийн статистикийн түлхүүр үзүүлэлтүүд, тухайлбал, ажилгүйдлийг аймаг, дүүргээр гаргаж өгөх боломжийг бүрдүүлэх юм. Улаанбаатар хотын хэмжээнд дүүргүүд түүврийн бүлэг болох бөгөөд хамгийн цөөн өрхтэй 2 дүүргийг нэг бүлэгт хамруулж нийт 8 бүлэг, аймаг тус бүрийг түүврийн нэг бүлэг хэмээн үзэж (21 аймаг) нийт 29 түүврийн бүлэг үүсгэсэн. Энд Улаанбаатар хотын дүүрэг, хорооны бүх хэсгүүд, аймгийн түвшинд сумын нийт багууд нь ТАШН болох юм. Ажиллах хүчний түүвэр судалгаанд 12288 өрх хамрагдах бөгөөд сар тутам 1024 өрх шинээр түүвэрлэгдэх болно. Судалгааны түүвэрлэлтийн хүрээ нь Монголын нийт өрх бөгөөд үүнд Хүн ам, өрхийн 2005 оны жилийн эцсийн тайлан, мэдээний үр дүнг ашигласан.

Эхлээд түүврийн анхан шатны нэгжүүдийг аймаг, нийслэл сум, дүүргийн нэрийн дагуу жагсааж ТАШН-ийн хувийн дугаар, нэгж бүрд тоологдсон өрхийн тоог жагсааж түүврийн хүрээг бэлтгэсэн.

Түүвэрт хичнээн өрх хамрагдах нь судалгааны санхүүжилтээс болон түүвэр судалгааны үр дүнгийн нарийвчлалаас ихээхэн хамаарна. Судалгаанд хамрагдсан 12288 өрхөөс авсан мэдээлэл нь монгол улсын нийт өрхүүдийг төлөөлөхдөө судалгааны асуулгаар цуглуулсан мэдээллийн бодит байдал үндэсний хэмжээнд 4 хувиас хэтрэхгүй алдааны магадлалтай ба түүвэрлэлтийн загварын нөлөөний утга нь 1.5-аас хэтрэхгүй байхаар түүвэрлэлтийг хийсэн.

Түүвэрлэлтийг хийхдээ 2 шатат түүврийн аргыг хэрэглэсэн. Эхний шатанд ТАШН, хоёр дахь шатанд түүвэрлэгдсэн анхан шатны нэгж дэх өрхийг сонгосон.

Эхний шатанд ТАШН-ийг хэмжээнд нь пропорциональ магадлалт түүврийн аргаар сонгосон. Түүвэрлэгдэх нэгжүүдийг ямар нэгэн үзүүлэлтээр нь жигнэж сонгох шаардлагатай үед энэ аргыг ашигладаг. Өөрөөр хэлбэл жин илүү байгаа нэгжийн түүвэрлэлтэд орох магадлал илүү байна гэсэн үг.

Манай тохиолдолд ТАШН-ийн хүн амын тоо их байх тусам тухайн ТАШН сонгогдох магадлал нь өндөр болж байгаа юм.

Хэмжээнд пропорциональ магадлалт түүврийн аргаар анхан шатны нэгжийг сонгоход ТАШН дэхь хүн амын тоо M_{hi} -г хэмжээний тодорхойлогч болгон ашигласан. Бүлэглэлт тус бүрээс хэмжээнд пропорциональ магадлалт

системчилсэн түүврийн аргыг (ХПМСТ) түүвэрлэлт хийхэд хэрэглэсэн болно. Түүвэрлэлтийн үйл ажиллагааг дараах байдлаар үзүүлэв.

“ h ” бүлэг доторх ‘ i ’ ТАШН-ийн түүвэрлэгдэх магадлал дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$P_{hi}^{(i)} = \frac{a_h M_{hi}}{M_h}$$

Үүнд:

a_h = бүлэг тус бүрээс авсан ТАШН-ийн тоо

M_{hi} = ‘ i ’ ТАШН-д түүврийн хүрээнд тодорхойлогдсон хүн амын тоо

$M_h = \sum M_{hi}$ = бүлэг бүр дэх түүврийн хүрээгээр тогтоогдсон нийт хүн амын тоо

“ h ” бүлэг дэх ТАШН-үүдийг аймаг, сумын нэрийн дагуу жагсааж ТАШН-ийн түүвэрлэлтийг хийсэн ба тогтоогдсон хүн амын тоог хэмжээний үзүүлэлт M_{hi} болгож авсан юм. “ M_{hi} ” өсөн нэмэгдэх утгуудыг тооцоолж уг утгуудыг ТАШН тус бүрийн харалдаа тавьсан болно. Түүврийн интервал I_{hi} -ийг дараах байдлаар тооцоолсон

$$I_{hi} = \frac{M_h}{a_h} \text{ хамгийн ойр бүхэл тоонд шилжүүлнэ.}$$

“ R_h ” санамсаргүй тоо нь 0-с I_{hi} хүртэлх дурын тоо байх ба үүнийг Excel программын санамсаргүй тооны функцийн тусламжтайгаар тодорхойлов. “ a_h ” тодорхойлогч тоонуудын дарааллыг өмнөх сонгогдсон тоон дээр I_{h1} -г нэмж олсон болно.

$$R_h, (R_h + I_{h1}), (R_h + 2I_{h1}), (R_h + 3I_{h1}), \dots, (R_h + (j-1)I_{h1}), (R_h + (a_h - 1)I_{h1})$$

Хоёр дахь шатанд ТАШН-ийг сонгосны дараа сонгогдсон ТАШН бүрээс түүвэр олонлогийг бүрдүүлэх өрхүүдийг энгийн санамсаргүй системчилсэн түүврийн аргаар сонгоно.

Дээр бид бүхэн ТАШН-ийн түүвэрлэлтийг 2005 оны жилийн эцсийн Хүн ам, өрхийн тайлан мэдээн дээр үндэслэн хийсэн гэдгийг дурьдсан. Харин түүврийн хоёр дахь шатны нэгж буюу өрхийн түүвэрлэлтийг хийхдээ ТАШН-д хичнээн өрх хамрагдаж буйг шинэчлэн гаргах хэрэгтэй болно. Үүний тулд хэмжээнд нь пропорциональ магадлалт түүврийн аргаар сонгогдсон ТАШН-д одоогийн байдлаар хамрагдаж байгаа нийт өрхүүдийн жагсаалтыг нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсээр гаргуулан авсан.

Ирүүлсэн өрхийн жагсаалтыг 1) хүүхэд нь хөдөлмөр эрхэлдэг, 2) хүүхэдгүй-хүүхэд нь хөдөлмөр эрхэлдэггүй гэсэн ангиллаар бүлэглэн бүлэг тус бүрээс дэд түүвэрлэлтийг тэнцүү 6 өрхийг энгийн санамсаргүй түүврийн аргаар сонгож, судалгааны түүвэр олонлогийг бүрдүүлсэн.

Түүврийн жин

Түүврийн жин доорхи томъёоны дагуу тодорхойлогдоно:

$$M_{srij} = \frac{P_s \times H_{srij}}{n_{sr} \times p_{sri} \times h_{srij}} - \text{Дэд түүвэрлэлт тус бүр дэх түүврийн анхан}$$

шатны жинг тооцох томьёо

$$M_{sij} = \frac{1}{2} \times \frac{P_s \times H_{srij}}{n_{sr} \times p_{sri} \times h_{srij}} - \text{Дэд түүвэрлэлтийг нэгтгэсэн түүврийн анхан}$$

шатны нэгжийн жинг тооцох томьёо

$$M_{tsij} = \frac{1}{2} \times \frac{P_s \times H_{srij}}{n_{tsr} \times p_{sri} \times h_{srij}} - \text{t-р улирлын жингийн томьёо}$$

P, p, n, H & h-ийн утгууд

- P – тухайн бүлгийн хэмжээ буюу бүлгийн нийт хүн амын тоо.
- p – тухайн анхан шатны нэгж дэх нийт хүн амын тоо
- n – тухайн дэд түүвэрлэлтээр тоологдох түүврийн анхан шатны нэгжийн тоо
- H – тухайн бүлгийн анхан шатны нэгжийн дэд түүвэрлэлт дэх өрхийн нийт тоо.
- h – тухайн бүлгийн анхан шатны нэгжийн дэд түүвэрлэлт дэх түүвэрлэгдэх өрхийн тоо .

Үнэлгээ хийх томьёо:

r – дэд түүвэрлэлтийн s бүлгийн жилийн Y-утгын үнэлгээний томьёо

$$\hat{Y}_{sr} = \frac{P_s}{n_{sr}} \sum_{i=1}^{n_{sr}} \frac{D_{sri}}{p_{sri}} \sum_{j=1}^2 \frac{H_{srij}}{h_{srij}} \sum_{k=1}^{h_{srij}} \sum_l y_{srikl}$$

Хэрвээ үнэлгээг улирал тус бүрд судалгаанд хамрагдсан түүврийн анхан шатны нэгжийн тоонд үндэслэн хийвэл доорх томьёог ашиглана.

$$\hat{Y}_{tsr} = \frac{P_s}{n_{tsr}} \sum_{i \in Q_t} \frac{D_{sri}}{p_{sri}} \sum_{j=1}^2 \frac{H_{srij}}{h_{srij}} \sum_{k=1}^{h_{srij}} \sum_l y_{srikl}, t=1, 2, 3, 4$$

Нэгдсэн үнэлгээ хийх:

Хоёр дэд түүвэрлэлтэд үндэслэсэн \hat{Y} -үзүүлэлтийг үнэлэхдээ дараахь томьёог ашиглана:

$$\hat{Y}_s = \frac{1}{2} \sum_{r=1}^2 \hat{Y}_{sr}$$

\hat{Y} -үзүүлэлтийг улсын түвшинд тооцохдоо бүлэг тус бүрийн \hat{Y}_s -ийн нийлбэрүүдийн дүнгээр тооцоолно.

Харьцааг цнэлэх

Харьцаа нь дараахь байдлаар илэрхийлэгдэнэ

$$R = \frac{Y}{X} (X - \text{эх олонлогийн туслах үзүүлэлтийн нийт дүн}) \text{ эндээс } \hat{R} = \frac{\hat{Y}}{\hat{X}} \text{ болно.}$$

Алдааг цнэлэх

Алдааг тооцохдоо дэд түүвэрлэлт дээр үндэслэн бүлэг тус бүрийн тооцооны утгын нийлбэрийн дүнгээр тооцоолно. \hat{Y} болон \hat{X} -ийн үзүүлэлтүүдийн хувьд дараахь хэлбэртэй байна:

$$\hat{V}(\hat{Y}) = \frac{1}{4} \sum_s (\hat{Y}_{s1} - \hat{Y}_{s2})^2$$

$$\hat{V}(\hat{R}) = \sum_s [(\hat{Y}_{s1} - \hat{Y}_{s2})^2 - 2\hat{R}(\hat{Y}_{s1} - \hat{Y}_{s2})(\hat{X}_{s1} - \hat{X}_{s2}) + \hat{R}^2(\hat{X}_{s1} - \hat{X}_{s2})^2] \div 4\hat{X}^2$$

\hat{Y}_{s1} болон \hat{Y}_{s2} нь s-р бүлгийн дэд түүвэрлэлт 1, 2 –ийн үнэлгээ байх бөгөөд харин \hat{X}_{s1} болон \hat{X}_{s2} нь X-д суурилсан дэд түүвэрлэлт 1, 2 –ийн үнэлгээ байна.

\hat{Y} болон \hat{R} -ийн харьцангуй стандарт алдаа (RSE) нь дараахь томъёогоор илэрхийлэгдэнэ:

$$RSE(\hat{Y}) = \frac{\sqrt{\hat{V}(\hat{Y})}}{\hat{Y}} \times 100 = \frac{\hat{Y}_1 - \hat{Y}_2}{\hat{Y}_1 + \hat{Y}_2} \times 100$$

эсвэл

$$RSE(\hat{R}) = \frac{\sqrt{\hat{V}(\hat{R})}}{\hat{R}} \times 100$$

10.3 Түцврийн алдаа

Түүвэр судалгаа хийгдэж байгаатай уялдан дараахь 2 төрлийн алдаа гарч байдаг. Үүнд

1) түүвэрлэлтийн алдаа; 2) түүвэрлэлтийн бус алдаа;

Түүвэрлэлтийн бус алдаа нь тоон мэдээллийг цуглуулах, боловсруулах, тархаах үйл явцын үед гардаг. Энэхүү алдаанд судалгааны бэлтгэл үе шат, мэдээлэл цуглуулах үед хийсэн тоологч, мэдээлэгчийн санамсаргүй болон санаатай хийсэн алдаа, боловсруулалтын шатанд гарсан алдааг хамруулж авч үздэг. Түүвэрлэлтийн бус алдаа нь түүврийн үр дүнгийн алдааны ихэнх хувийг эзэлдэг бөгөөд түүврийн дизайн болон түүвэр судалгааг явуулах үе шатуудаас хамаардаггүй. Түүвэрлэлтийн бус алдаа нь гарсаар байдаг бөгөөд судалгааг явуулах бүхий л үе шатанд багасгах арга хэмжээг авдаг. Нөгөөтэйгүүр түүвэрлэлтийн бус алдааг статистикийн аргаар тооцоолох боломж хомс байдаг. Харин түүвэрлэлтийн алдааг статистикийн аргаар тооцолдог.

Нийт олонлогоос түүвэрлэн авсан ажиглалт дээр тулгуурлан үр дүнг тооцдогдоос улбаалан түүвэрлэлтийн алдаа гардаг. Түүвэрлэлтийн алдаа тухайн судалгааг хийхэд ашигласан түүврийн төрөл болон түүврийн хэмжээнээс хамаарна. Энэхүү алдааг боломжит түвшинд байлгах үүднээс түүврийн загварыг болон түүврийн хэмжээг сонгосон.

Улсын хэмжээнд тодорхойлогдсон түүврийн анхан шатны нэгж бүрээс тус түүвэрт сонгогдсон түүврийн нэгжээс судалгаа авч үр дүнг тооцсонтой холбоотойгоор судалгааны үр дүн бодит утгаас ямар хэмжээний хэлбэлзэлтэй байгааг түүвэрлэлтийн алдаа илэрхийлнэ. Түүврийн загвар болон түүврийн хэмжээнд тулгуурлан алдааг тооцсон бөгөөд зарим нэг үзүүлэлтийн алдааны хязгаар өндөр байх нь түүврийн загварыг сонгох үе шатанд харагдаж байсан.

Судалгааны түүвэрлэлтийн алдааг дараахь үзүүлэлтийн тусламжтайгаар тооцоолсон бөгөөд түүврийн алдааг илэрхийлэх гол үзүүлэлт нь вариацийн коэффициент болно.

- Ерөнхий олонлогийн үзүүлэлтийн тооцооны утга
- Стандарт алдаа
- Вариацийн коэффициент
- 95 хувийн итгэмжлэгдэх интервал
- Тооцоо хийхэд ашиглагдсан ажиглалтын тоо

5. Түүвэрлэлтийн алдааг судалгааны үндсэн үзүүлэлтүүдийн хувьд улсын түвшин, хот, хөдөө, хүйсээр, бүс нутаг, аймгийн хэмжээнд гэсэн ангиллаар тооцсон.

Хүснэгт 35

Нийт хүн ам

	Тооцооны утга	Ажиглалтын тоо	Стандарт алдаа	95% итгэмжлэгдэх интервал		Вариацийн коэффициент
				Доод	Дээд	
НИЙТ	2,193,037	47,190	3289.1	2,186,459	2,199,615	0.1
ХОТ, ХӨДӨӨ						
Хот	1,285,204	28,124	18607.9	1,247,988	1,322,420	1.4
Хөдөө	907,833	19,065	21897.0	864,039	951,627	2.4
ХҮЙС						
Эрэгтэй	1,073,518	23,132	5700.5	1,062,117	1,084,919	0.5
Эмэгтэй	1,119,519	24,057	8982.6	1,101,554	1,137,484	0.8
БҮС						
Баруун	375,575	7,764	1195.5	373,184	377,965	0.3
Хангай	510,679	10,007	3682.3	503,314	518,043	0.7
Төв	371,759	8,389	13867.5	344,024	399,494	3.7
Зүүн	179,902	3,819	9606.6	160,689	199,115	5.3
Улаанбаатар	755,130	17,211	5063.2	745,003	765,256	0.7
АЙМАГ						
Архангай	82,144	1,405	2976.7	76,190	88,097	3.6
Баян-Өлгий	92,185	2,228	4366.3	83,453	100,918	4.7
Баянхонгор	82,180	1,633	236.4	81,707	82,652	0.3
Булган	56,549	1,141	3717.5	49,114	63,984	6.6
Говь-Алтай	52,772	1,067	2531.5	47,709	57,835	4.8
Дорноговь	49,389	1,048	2065.7	45,257	53,520	4.2
Дорнод	65,161	1,477	3133.1	58,895	71,428	4.8
Дундговь	44,236	1,164	895.5	42,445	46,027	2.0
Завхан	72,069	1,407	333.9	71,402	72,737	0.5
Өвөрхангай	94,362	1,752	1245.9	91,870	96,854	1.3
Өмнөговь	40,152	1,152	543.5	39,065	41,239	1.4
Сүхбаатар	52,680	1,227	2081.8	48,517	56,844	4.0
Сэлэнгэ	77,315	1,439	4179.8	68,955	85,675	5.4
Төв	72,156	1,333	626.7	70,902	73,409	0.9
Увс	78,976	1,512	4086.8	70,803	87,150	5.2
Ховд	79,571	1,550	1281.7	77,008	82,135	1.6
Хөвсгөл	113,893	2,615	173.4	113,546	114,240	0.2
Хэнтий	62,061	1,115	4391.7	53,277	70,844	7.1
Дархан-Уул	79,104	1,866	8140.9	62,822	95,385	10.3
Улаанбаатар	755,130	17,211	5063.2	745,003	765,256	0.7
Орхон	81,552	1,461	3587.0	74,378	88,726	4.4
Говьсүмбэр	9,408	387	244.1	8,919	9,896	2.6

Хүснэгт 36

Ажиллах хүч

	Тооцооны утга	Ажиглалтын тоо	Стандарт алдаа	95% итгэмжлэгдэх интервал		Вариацийн коэффициент
				Доод	Дээд	
НИЙТ	1,013,465	21,670	5108.2	1,003,249	1,023,681	0.5
ХОТ, ХӨДӨӨ						
Хот	529,195	11,551	6211.1	516,773	541,617	1.2
Хөдөө	484,270	10,119	11319.3	461,631	506,909	2.3
ХҮЙС						
Эрэгтэй	522,471	11,165	6293.2	509,884	535,057	1.2
Эмэгтэй	490,994	10,505	1185.0	488,624	493,364	0.2
БҮС						
Баруун	183,018	3,786	3202.7	176,612	189,423	1.7
Хангай	259,462	5,116	836.4	257,790	261,135	0.3
Төв	186,039	4,164	4815.4	176,408	195,669	2.6
Зүүн	75,904	1,603	3618.5	68,667	83,141	4.8
Улаанбаатар	309,042	7,001	2266.0	304,510	313,574	0.7
АЙМАГ						
Архангай	46,082	818	1270.5	43,541	48,623	2.8
Баян-Өлгий	34,971	841	2408.8	30,154	39,789	6.9
Баянхонгор	41,119	828	1814.7	37,490	44,749	4.4
Булган	28,033	531	1500.1	25,033	31,033	5.4
Говь-Алтай	27,425	571	1043.5	25,338	29,512	3.8
Дорноговь	24,899	550	43.2	24,813	24,986	0.2
Дорнод	24,081	531	1209.5	21,662	26,500	5.0
Дундговь	20,883	556	178.7	20,526	21,240	0.9
Завхан	37,064	726	476.4	36,111	38,016	1.3
Өвөрхангай	46,508	837	2907.8	40,692	52,324	6.3
Өмнөговь	21,946	594	811.6	20,322	23,569	3.7
Сүхбаатар	25,852	610	2259.9	21,332	30,371	8.7
Сэлэнгэ	38,390	694	647.1	37,095	39,684	1.7
Төв	40,642	768	2828.3	34,985	46,298	7.0
Увс	41,633	819	4285.1	33,063	50,203	10.3
Ховд	41,926	829	1893.5	38,139	45,713	4.5
Хөвсгөл	64,183	1,490	1906.8	60,370	67,997	3.0
Хэнтий	25,972	462	149.1	25,674	26,270	0.6
Дархан-Уул	35,549	843	2713.1	30,123	40,975	7.6
Улаанбаатар	309,042	7,001	2266.0	304,510	313,574	0.7
Орхон	33,536	612	791.4	31,953	35,119	2.4
Говьсүмбэр	3,730	159	426.1	2,878	4,582	11.4

Хүснэгт 37

Ажиллагсад

	Тооцооны утга	Ажиглалтын тоо	Стандарт алдаа	95% итгэмжлэгдэх интервал		Вариацийн коэффициент
				Доод	Дээд	
НИЙТ	898,932	19,226	770.3	897392	900473	0.1
ХОТ, ХӨДӨӨ						
Хот	442,498	9712	7490.8	427516	457480	1.7
Хөдөө	456,434	9514	8261.1	439912	472956	1.8
ХҮЙС						
Эрэгтэй	463,780	9931	3368.9	457042	470518	0.7
Эмэгтэй	435,152	9,295	2598.6	429955	440350	0.6
БҮС						
Баруун	169,259	3,531	2544.2	164170	174347	1.5
Хангай	235,910	4679	254.0	235402	236418	0.1
Төв	162,186	3604	2452.5	157280	167091	1.5
Зүүн	66,573	1,428	1482.5	63608	69538	2.2
Улаанбаатар	265,006	5,984	549.9	263906	266105	0.2
АЙМАГ						
Архангай	42,302	753	2951.1	36399	48204	7.0
Баян-Өлгий	33,368	794	2375.6	28617	38120	7.1
Баянхонгор	39,052	791	2205.5	34641	43463	5.6
Булган	25,296	468	1384.3	22527	28065	5.5
Говь-Алтай	25,329	527	390.8	24547	26110	1.5
Дорноговь	20,422	438	544.6	19333	21511	2.7
Дорнод	23,969	526	1283.8	21401	26537	5.4
Дундговь	18,823	502	53.4	18716	18930	0.3
Завхан	32,991	668	48.6	32893	33088	0.1
Өвөрхангай	44,437	791	3137.6	38161	50712	7.1
Өмнөговь	19,778	533	1294.8	17189	22368	6.5
Сүхбаатар	20,346	494	790.2	18766	21927	3.9
Сэлэнгэ	34,773	624	176.6	34420	35126	0.5
Төв	37,620	710	1511.7	34597	40644	4.0
Увс	38,834	776	3127.4	32579	45089	8.1
Ховд	38,737	766	2231.8	34273	43201	5.8
Хөвсгөл	61,274	1,428	1599.2	58076	64472	2.6
Хэнтий	22,258	408	591.6	21074	23441	2.7
Дархан-Уул	28,104	682	2415.0	23274	32935	8.6
Улаанбаатар	265,006	5,984	549.9	263906	266105	0.2
Орхон	23,550	448	337.4	22875	24225	1.4
Говьсүмбэр	2,665	115	242.0	2181	3149	9.1

Хүснэгт 38

Ажилгүйчүүд

	Тооцооны утга	Ажиглалтын тоо	Стандарт алдаа	95% итгэмжлэгдэх интервал		Вариацийн коэффициент
				Доод	Дээд	
НИЙТ	114,533	2,444	4337.9	105856.9	123208.6	3.8
ХОТ, ХӨДӨӨ						
Хот	86,697	1839	1279.7	84137.6	89256.3	1.5
Хөдөө	27,836	605	3058.3	21719.3	33952.3	11.0
ХҮЙС						
Эрэгтэй	58,691	1234	2924.3	52842.2	64539.4	5.0
Эмэгтэй	55,842	1210	1413.6	53014.7	58669.2	2.5
БҮС						
Баруун	13,759	255	658.5	12442.1	15076.2	4.8
Хангай	23,553	437	1090.4	21371.9	25733.6	4.6
Төв	23,853	560	2362.9	19127.3	28578.9	9.9
Зүүн	9,331	175	2136.0	5059.0	13603.1	22.9
Улаанбаатар	44,037	1,017	2815.9	38405.0	49668.5	6.4
АЙМАГ						
Архангай	3,781	65	1680.6	419.7	7142.0	44.4
Баян-Өлгий	1,603	47	33.2	1536.3	1669.1	2.1
Баянхонгор	2,068	37	390.8	1286.0	2849.3	18.9
Булган	2,737	63	115.9	2505.6	2969.0	4.2
Говь-Алтай	2,096	44	652.7	790.5	3401.3	31.1
Дорноговь	4,478	112	587.8	3301.9	5653.1	13.1
Дорнод	112	5	74.3	-37.0	260.3	66.6
Дундговь	2,060	54	125.3	1809.6	2310.7	6.1
Завхан	4,073	58	525.0	3023.0	5123.0	12.9
Өвөрхангай	2,071	46	229.8	1611.8	2531.0	11.1
Өмнөговь	2,167	61	483.2	1200.7	3133.5	22.3
Сүхбаатар	5,505	116	1469.7	2565.9	8444.6	26.7
Сэлэнгэ	3,616	70	470.6	2675.3	4557.6	13.0
Төв	3,022	58	1316.6	388.4	5654.8	43.6
Увс	2,799	43	1157.7	483.5	5114.4	41.4
Ховд	3,189	63	338.3	2511.9	3865.2	10.6
Хөвсгөл	2,909	62	307.6	2294.0	3524.5	10.6
Хэнтий	3,714	54	740.7	2232.8	5195.6	19.9
Дархан-Уул	7,445	161	298.0	6848.8	8040.9	4.0
Улаанбаатар	44,037	1017	2815.9	38405.0	49668.5	6.4
Орхон	9,986	164	453.9	9078.5	10894.3	4.5
Говьсүмбэр	1,065	44	668.0	-270.6	2401.4	62.7

Хүснэгт 39

Хөдөлмөр эрхэлдэг хүүхэд

	Тооцооны утга	Ажиглалтын тоо	Стандарт алдаа	95% итгэмжлэгдэх интервал		Вариацийн коэффициент
				Доод	Дээд	
НИЙТ	71330	1915	3538.9	64252.0	78407.8	5.0
ХОТ, ХӨДӨӨ						
Хот	7575	307	192.8	7189.0	7960.1	2.5
Хөдөө	63755	1608	3731.7	56291.9	71218.8	5.9
ХҮЙС						
Эрэгтэй	43037	1152	4518.9	33999.7	52075.2	10.5
Эмэгтэй	28292	763	979.9	26332.6	30252.3	3.5
НАСНЫ БҮЛГЭЭР						
5-9 насны	18116	393	1558.0	15000.4	21232.2	8.6
10-14 насны	25016	666	1886.9	21242.3	28789.8	7.5
15-17 насны	28198	856	94.1	28009.3	28385.8	0.3
БҮС						
Баруун	17635	416	406.4	16822.0	18447.7	2.3
Хангай	35128	857	2700.1	29727.9	40528.2	7.7
Төв	13109	457	1896.2	9316.8	16901.4	14.5
Зүүн	4032	134	489.4	3053.5	5011.3	12.1
Улаанбаатар	1425	51	161.4	1102.7	1748.2	11.3
АЙМАГ						
Архангай	7812	172	242.9	7326.6	8298.1	3.1
Баян-Өлгий	1695	49	322.9	1049.7	2341.3	19.0
Баянхонгор	3704	90	737.6	2228.6	5178.9	19.9
Булган	1340	18	966.2	-592.0	3272.7	72.1
Говь-Алтай	3870	99	1170.0	1530.4	6210.5	30.2
Дорноговь	390	27	1.9	386.3	393.7	0.5
Дорнод	1083	24	78.7	925.2	1240.0	7.3
Дундговь	979	43	16.0	946.8	1011.0	1.6
Завхан	1177	18	371.3	434.4	1919.7	31.5
Өвөрхангай	2952	83	15.3	2920.9	2982.2	0.5
Өмнөговь	1447	91	497.2	452.5	2441.5	34.4
Сүхбаатар	1958	75	741.9	474.3	3442.0	37.9
Сэлэнгэ	3914	93	703.2	2507.9	5320.6	18.0
Төв	5251	151	1057.1	3137.2	7365.6	20.1
Увс	4401	130	359.3	3682.1	5119.5	8.2
Ховд	6491	120	1098.5	4294.2	8688.1	16.9
Хөвсгөл	19276	491	1258.6	16759.2	21793.7	6.5
Хэнтий	992	35	173.8	644.1	1339.2	17.5
Дархан-Уул	1075	47	383.0	308.7	1840.7	35.6
Улаанбаатар	1425	51	161.4	1102.7	1748.2	11.3
Орхон	44	3	34.7	-25.8	113.0	79.6
Говьсүмбэр	53	5	35.8	-18.8	124.5	67.7

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан хүн амын тоо, насны бүлэг, хүйс, байршлаар

		Хувиар			Хүний тоо	
		Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд		
Нийт хүн ам		49.0	51.0	100.0	2,237,332	
Насны бүлэг	0-4	49.8	50.2	100.0	175,571	
	5-9	51.7	48.3	100.0	209,127	
	10-14	53.3	46.7	100.0	237,149	
	15-19	50.7	49.3	100.0	278,816	
	20-24	47.6	52.4	100.0	210,246	
	25-29	46.5	53.5	100.0	187,117	
	30-34	48.9	51.1	100.0	184,566	
	35-39	47.5	52.5	100.0	168,625	
	40-44	47.0	53.0	100.0	159,786	
	45-49	47.2	52.8	100.0	131,207	
	50-54	46.5	53.5	100.0	95,932	
	55-59	46.5	53.5	100.0	61,521	
	60-64	48.9	51.1	100.0	52,279	
	65-69	48.8	51.2	100.0	33,393	
	70+	43.5	56.5	100.0	51,997	
	5-17 насны хүүхэд		52.4	47.6	100.0	621,612
	Хөдөлмөрийн насны хүн (16-59 нас)		47.9	52.1	100.0	1,419,482
5-аас дээш насны хүн ам		48.9	51.1	100.0	2,061,760	
15-аас дээш насны хүн ам		47.9	52.1	100.0	1,615,484	
Хот-Бүгд		47.8	52.2	100.0	1,310,504	
5-17 насны хүүхэд		51.6	48.4	100.0	350,472	
Хөдөлмөрийн насны хүн (16-59 нас)		46.4	53.6	100.0	856,010	
5-аас дээш насны хүн ам		47.6	52.4	100.0	1,220,311	
15-аас дээш насны хүн ам		46.4	53.6	100.0	978,431	
Хөдөө-Бүгд		50.6	49.4	100.0	926,828	
5-17 насны хүүхэд		53.4	46.6	100.0	271,140	
Хөдөлмөрийн насны хүн (16-59 нас)		50.2	49.8	100.0	563,472	
5 ба түүнээс дээш насны хүн ам		50.8	49.2	100.0	841,449	
15 ба түүнээс дээш насны хүн ам		50.1	49.9	100.0	637,053	

**Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан хүн амын тоо, бүс, аймаг,
нийслэлээр**

Бүс, аймаг/ нийслэл		Хувиар			Хүний тоо
		Эрэгтэй	Эмэгтэй	Дүн	
Нийт хүн ам		49.0	51.0	100.0	2,237,332
Бүсээр	Баруун	49.6	50.4	100.0	384,301
	Хангай	49.9	50.1	100.0	522,079
	Төв	49.5	50.5	100.0	378,675
	Зүүн	49.9	50.1	100.0	183,505
	Улаанбаатар	47.6	52.4	100.0	768,771
Аймаг/ Нийслэл	Архангай	49.9	50.1	100.0	84,173
	Баян-Өлгий	49.4	50.6	100.0	95,237
	Баянхонгор	49.7	50.3	100.0	83,670
	Булган	51.0	49.0	100.0	58,480
	Говь-Алтай	49.3	50.7	100.0	53,991
	Дорноговь	47.8	52.2	100.0	50,533
	Дорнод	50.3	49.7	100.0	66,634
	Дундговь	51.2	48.8	100.0	45,163
	Завхан	49.5	50.5	100.0	72,816
	Өвөрхангай	49.2	50.8	100.0	96,436
	Өмнөговь	50.3	49.7	100.0	40,774
	Сүхбаатар	47.4	52.6	100.0	53,635
	Сэлэнгэ	49.4	50.6	100.0	78,775
	Төв	51.0	49.0	100.0	73,299
	Увс	50.6	49.4	100.0	81,149
	Ховд	49.0	51.0	100.0	81,107
	Хөвсгөл	51.1	48.9	100.0	116,061
	Хэнтий	51.6	48.4	100.0	63,237
	Дархан-Уул	48.2	51.8	100.0	80,569
	Улаанбаатар	47.6	52.4	100.0	768,771
Орхон	48.6	51.4	100.0	83,260	
Говьсүмбэр	47.5	52.5	100.0	9,561	

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан өрхийн тоо, өрхийн тэргүүлэгчийн хүйс, өрхийн ам бүлийн тоо, байршил, бүс, аймаг, нийслэлээр

Ам бүлийн тоо		Хувиар			Өрхийн тоо
		Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх	Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх	Дүн	
Бүгд		79.5	20.5	100.0	597,218
	1	52.8	47.2	100.0	45,441
	2-3	72.5	27.5	100.0	220,674
	4-6	87.7	12.3	100.0	301,062
	7+	88.7	11.3	100.0	30,041
Хот	1	45.8	54.2	100.0	22,749
